

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2015 оны 12 дугаар сарын 31

Зуунмод

Нэг. Ерөнхий зүйл


Үндэсний аудитын газрын харьяа Төв аймгийн Аудитын газар нь 2015 онд Монгол Улсын Төрийн аудитын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгон аудитын олон улсын стандартын хүрээнд үйл ажиллагаагаа явууллаа.

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн аудитын байгууллагын удирдах ажилтны зөвөлгөөнөөр дэвшүүлсэн зорилтын хүрээнд 2015 оны аудитын болон үйл ажиллагааны төлөвлөгөөг 55 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр боловсруулан аудитор, шинжээч нарын үр дүнгийн гэрээнд тусгуулан хэрэгжилтийг улирал хагас бүтэн жилээр тооцон ажиллаа. Мөн түүнчлэн тайлант онд орон нутагт Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэх зорилтыг тавьж аудит болгонд тодорхой зорилт болгон тусгаж хэрэгжүүллээ.

Төв аймгийн Аудитын газар нь www.audit.mn веб сайтаар 2015 онд хийсэн бүх аудитын тайлан, дүгнэлтийг байршуулан олон нийтэд мэдээлэл хүргэх арга хэмжээг авч хэрэгжүүллээ.

ҮАГ-тай нэгдсэн сүлжээнд холбогдсноор онлайн хуралд оролцож, мэдээ тайланг шуурхай хүргэж ажилласан байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2014 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 203 тоот тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн аудитын шинэ журам, гарын авлагыг хэрэгжүүлэн ажиллаа.



№	Тайлангийн нэр	Тайлангийн төрөл	Тайлангийн үнэ	Тайлангийн хугацаа	Тайлангийн үнэ	Тайлангийн хугацаа
1	Төрийн аудитын газрын 2014 оны үйл ажиллагааны тайлан	Төрийн аудитын газрын 2014 оны үйл ажиллагааны тайлан	1000000000.00	2014.12.31	1000000000.00	2014.12.31
2	Төрийн аудитын газрын 2014 оны үйл ажиллагааны тайлан	Төрийн аудитын газрын 2014 оны үйл ажиллагааны тайлан	1000000000.00	2014.12.31	1000000000.00	2014.12.31
3	Төрийн аудитын газрын 2014 оны үйл ажиллагааны тайлан	Төрийн аудитын газрын 2014 оны үйл ажиллагааны тайлан	1000000000.00	2014.12.31	1000000000.00	2014.12.31
4	Төрийн аудитын газрын 2014 оны үйл ажиллагааны тайлан	Төрийн аудитын газрын 2014 оны үйл ажиллагааны тайлан	1000000000.00	2014.12.31	1000000000.00	2014.12.31
5	Төрийн аудитын газрын 2014 оны үйл ажиллагааны тайлан	Төрийн аудитын газрын 2014 оны үйл ажиллагааны тайлан	1000000000.00	2014.12.31	1000000000.00	2014.12.31

Үндэсний аудитын газраас 2014 онд нэвтрүүлж эхэлсэн Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем (СТАУС) программыг 2014 оны санхүүгийн тайлангийн аудитад бүрэн ашигласан. Санхүүгийн аудитад уг программыг ашигласнаар орон нутгийн байгууллагуудаа манлайлж, тодорхой хэмжээгээр цаг хугацаа хэмнэж, хянан удирдах үйл ажиллагааны арга зүйг стандартын дагуу хэрэгжүүллээ.


СТАУС программд 2015 оны санхүүгийн тайланд аудит хийх 252 үйлчлүүлэгч байгууллагын сонголттой мэдээлэл, ерөнхий мэдээлэл, удирдлагын мэдээлэл, нягтлан бодогчийн мэдээллийг бүрэн орууллаа.

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2014 оны 22 тоот тушаалаар аймгийн Аудитын газрын чиг үүрэг, бүтэц, орон тоог батлах тухай тушаалын дагуу гүйцэтгэлийн аудитын гурван ажилтан, санхүүгийн аудитын хоёр багтай, бусад ажилтан хоёр байхаар зохион байгуулан ажиллаж байна. Уг тушаалаар 12 үндсэн орон тоо батлагдсан ба үйлчилгээний 2 ажилтны цалингийн санг аймгийн ИТХурлаар батлуулан нийт 14 орон тоогоор ажиллаа.

2015 онд хийгдсэн санхүүгийн, гүйцэтгэлийн, нийцлийн аудитаар нийт 521.2 сая төгрөгийн төлбөрийн акт бичигдсэнээс 401.8 сая төгрөгийг барагдуулж актын барагдуулалт 77.1 хувийн биелэлттэй байна. Мөн аудитаар нийт 43025.7 сая төгрөгийн албан шаардлага бичигдэж хэрэгжилт 98.2 хувийн биелэлттэй. Албан шаардлагаар аймаг сумын төсөвт 544.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нийт санхүүгийн үр өгөөж 16633.3 сая төгрөг, санхүүгийн бус үр өгөөж 27-г бүртгэж, харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн үр өгөөж нь 10024.1 сая төгрөг, санхүүгийн бус үр өгөөж 27 буюу Төв аймгийн Аудитын газрын 2015 оны жилийн төсвийн гүйцэтгэлтэй харьцуулахад зардлын 1 төгрөгт ноогдох өгөөж 36.33 төгрөг болж байна.

Санхүүжилтийн 1 төгрөгт ноогдох үр өгөөж



Хоёр. Санхүүгийн тайлангийн аудит.

Төв аймгийн Аудитын газар нь 2015 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу улс, орон нутгийн төсвийн болон тусгай шилжүүлгийн байгууллага, тусгай сангууд, төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан зэрэг нийт 314 санхүүгийн тайланд аудит хийж дүгнэлт гарган ажиллаа. Дээрх байгууллагуудаас 86 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгаж, 184 байгууллагын санхүүгийн тайланд санал дүгнэлт гаргаж, Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаалаар 44 байгууллагад итгэл үзүүлсэн байна.

Аудитын дүгнэлт гаргасан байгууллагуудын 80.4 хувь буюу 148 байгууллагын санхүүгийн тайланд зөрчилгүй санал дүгнэлт, 35 байгууллагад хязгаарлалттай санал дүгнэлт, 1 байгууллагад татгалзсан санал дүгнэлт гаргасан байна.



Санхүүгийн тайланд аудит хийхдээ УСНББОУС, СТОУС, Сангийн сайдын тушаалаар баталсан санхүүгийн тайлангийн аргачлал заавар журам, Санхүүгийн тайлангийн аудитын журам, Санхүүгийн аудитын гарын авлагын хүрээнд аудит хийлгэсэн байгууллагын санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн болон мөнгөн гүйлгээг нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартад нийцүүлэн үнэн зөв гаргасан эсэхэд дүгнэлт гаргахын тулд санхүүгийн тайлан нь материаллаг алдаагүй үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг нотолгоонд тулгуурлан дүгнэлт өгөв.

Үндэсний аудитын газраас 2014 онд нэвтрүүлж эхэлсэн Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем (СТАУС) программыг 2014 оны санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөлтийн, гүйцэтгэлийн, тайлагналын шатанд бүрэн ашигласан.

Санхүүгийн тайланд хамрагдсан байгууллагуудын аудитын тайлан, дүгнэлтийг www.audit.mn веб сайтад байршуулан олон нийтэд мэдээлэл хүргэх арга хэмжээг авч ажилласан. 2015 оны 04-р сарын 27–ээс 05-р сарын 07-ний өдрүүдэд бүх сумдад 3 чиглэлд ажиллаж сумдын удирдлага, төсөвт байгууллагын дарга, санхүүгийн ажилтнуудын нэгдсэн хуралд 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг дэлгэрэнгүй танилцуулсан.

2.1. Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2014 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд 2015 оны 04 дүгээр сарын 08-19-ны хооронд аудитыг хийж, дүгнэлт гаргалаа.

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 1564.0 сая төгрөгийн материаллаг алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 921.4 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 585.8 сая төгрөгийн албан шаардлага, 56.8 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох зөвлөмжийг хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшин 1132.0 сая төгрөгнөөс хэтрээгүй тул **зөрчилгүй санал дүгнэлт** өгөгдсөн.

Орлого, татаас санхүүжилтийн талаар. Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг батлагдсан төлөвлөгөөний дагуу 10176.3 сая төгрөгийг, Тусгай зориулалтын шилжүүлэг 35939.1 сая төгрөгийг бүрэн авсан байна. Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт 9618.2 сая төгрөгөөр батлагдсанаас, гүйцэтгэлээр 6890.8 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж, 2727.8 сая төгрөгөөр дутуу санхүүжигдсэн байна.

Төв аймгийн 2014 оны төсвийн орлого, эх үүсвэрийг аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаас 69431.8 сая төгрөгөөр баталсан. Аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас орон нутгийн төсөвт төвлөрөх татварын орлогыг 1549.2 сая төгрөгөөр тодотгож, 2014 оны аймгийн урсгал төсвийн орлого нийт 11071.3 сая төгрөгөөр батлагдсан байна.

Төв аймгийн 2014 оны Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аймгийн урсгал төсвийн орлого гүйцэтгэлээр 13344.6 сая төгрөг, үүнээс татварын буцаан олголт 524.6 сая төгрөгийг хасч тооцоход 12819.9 сая төгрөгөөр тайлагнагдсан. Үүнээс үзэхэд батлагдсан төлөвлөгөө 134.8 хувиар буюу 1748.6 сая төгрөгөөр давуулж биелсэн байна.

Татварын орлогын төлөвлөгөөний биелэлтийг авч үзвэл:

- Сумын орон нутгийн төсөвт төвлөрөх орлогын төлөвлөгөөг 20 сум 100.4-298.9 хувиар биелүүлж, Алтанбулаг, Баянжаргалан, Баянцагаан, Баянцогт, Дэлгэрхаан, Угтаал, Эрдэнэ зэрэг сумд 9.8-37.3 хувиар тасалж, нийт дүнгээр сумын орлогын төлөвлөгөөг 865.8 сая төгрөгөөр биелүүлж төлөвлөгөөний биелэлт 155.9 хувьтай байна.
- Аймгийн төвлөрсөн төсвийн орлогын төлөвлөгөөг 17 сум 102.0-143.9 хувиар давуулан биелүүлж, Баянжаргалан, Сүмбэр, Жаргалант зэрэг сумд нь 20.0-69.4 хувиар тасалсан бөгөөд аймгийн төвлөрсөн төсвийн орлого нийт дүнгээр 54.5 сая төгрөгөөр давж биелэсэн ба төлөвлөгөөний биелэлт 105.7 хувьтай байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар төсөвт газрын өөрийн орлого батлагдсан төлөвлөгөөгөөр 183.2 сая төгрөг, гүйцэтгэлээр 116.7 сая төгрөг орж, 66.5 сая төгрөгөөр дутуу буюу 64 хувийн биелэлттэй байна. Өөрийн орлогын төлөвлөгөөг Алтанбулаг, Баян-өнжүүл, Борнуур, Мөнгөнморьт, Угтаал сумдад 14.8 - 73.3 хувиар тасалсан байна.

Зарлагын талаар. Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2014 оны төсвийн гүйцэтгэлийн аудитлагдсан тайлангаар төсвийн зарлагын батлагдсан төлөвлөгөө 69437.9 сая төгрөг, гүйцэтгэл 75701.8 сая төгрөг байна.

Сангийн яам Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар аудитлагдсан төсвийн зарлагын төлөвлөгөөг 68761.4 сая төгрөгөөр, зарлагын гүйцэтгэлийг 75760.1 сая төгрөгөөр өөрчлөн нэгтгүүлсэн байна. Энэ нь төсвийн зарлагын төлөвлөгөөнөөс сумдын ИТХурлаар тодотгон баталсан 670.4 сая төгрөгийг хасч, төсвийн зарлагын гүйцэтгэлийг төрийн сангийн данснаас нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулсан 36.3 сая төгрөгийн санхүүжилт болон орон

нутгийн орлогын дансанд тусгай сангийн данснаас төвлөрүүлсэн 22.0 сая төгрөг, нийт 58.3 сая төгрөгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэмж тусгуулсантай холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар батлагдсан төлөвлөгөө нийт дүнгээр 6263.9 сая төгрөг хэтэрсэн нь Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын төлөвлөгөөг нэгтгээгүйгээс шалтгаалсан байна.

Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн зарлагын гүйцэтгэлийг сайдын багцаар авч үзвэл нийт зарлагын 38.4 хувийг аймгийн Засаг даргын багц, 34.7 хувийг БСШУСайдын багц, 8.1 хувийг Эрүүл мэндийн сайдын багцад зарцуулсан байгаа нь нийт зарлагын 81.2 хувийг эзэлж байна.

2.2. Орон нутгийн төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудит



Төв аймгийн Орон нутгийн 62 байгууллага аудитад хамрагдсанаас 82.2 хувь нь буюу 51 байгууллага зөрчилгүй санал дүгнэлттэй, 17.8 хувь буюу 11 байгууллага хязгаарлалтай санал дүгнэлт өгч ажилласан. Аудитаар нийт 7061.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 418.5 сая төгрөгийн алдааг залруулж, 46.9 сая төгрөгийн төлбөрийн акт, 5273.3 сая төгрөгийн албан шаардлага бичиж, 1323.3 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгөгдлөө.

ТШЗахирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн төсвийн зарцуулалттай холбоотой зөрчлөөс дурьдвал:

- Батлагдсан орон тооноос аймгийн ЗДТГазар нь Засаг даргын 1 орлогч, ГХБХБГазар 3 ажилтан, Хот тохижуулах газар 6 ажилтан Батсүмбэр сумын Ойн анги нь 1 ажилтан, Мөнгөнморьт сумын ойн анги нь 2 ажилтан тус тус илүү, Алтанбулаг, Сүмбэр, Баянхангай, Мөнгөнморьт, Угтаал, Эрдэнэ зэрэг сумдын ИТХурал нь хурлын ажилтан ажиллуулсан.
- Баян сум нь сумын Засаг даргын зөвлөх, Хөдөлмөр, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн, Цээл сум нь Барилгын ажил хянах хяналтын инженер гэрээгээр ажиллуулсан.
- Аймгийн ЗДТГазар болон Баян, Угтаал, Эрдэнэ, Дэлгэрхаан, Эрдэнэсант, Цээл зэрэг сумд нь цалингийн сангаас автомашины сэлбэг, эмэгтэйчүүдийн хүлээн авалт, удирдлагын зөвлөлийн хоолны үнэ, тэтгэмж, шагнал зэргийг олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан.
- Алтанбулаг, Батсүмбэр, Баянжаргалан, Дэлгэрхаан, Заамар, Мөнгөнморьт, Өндөрширээт, Сүмбэр, Эрдэнэ, Баян, Баянцогт, Баянчандмань, Сэргэлэн сумдууд цалингийн зардлаас торгууль суутгасныг төсөвт шилжүүлээгүй, нэмэгдэл хөлсийг олгохдоо тогтоосон журмаас хэтрүүлэн олгосон, шагнал тэтгэмжийг цалингаас олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан.
- Батсүмбэр сумын Иргэдийн хурлын төлөөлөгч нар нь ӨМӨЗОрны шилийн гол аймагт туршлага судлах нэрээр аялан 1.9 сая төгрөгийг, Баянжаргалан сум нь шинэ жилийн сугалаа, ардчилсан хувьсгал ялсны 25 жилийн ойд зориулсан үйл ажиллагаанд 1.2 сая төгрөг олгож төсвийг үр ашиггүй зарцуулсан.
- Батсүмбэр, Жаргалант сумдад багийн цэцэрлэг шинээр нэмж байгуулан орон тоо бүтцийг нэмэгдүүлээгүй өр үүсгэн жилийн эцэст хоолны хэмнэлтээс барагдуулсан байна.

2.3. Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудит

Төв аймгийн ТЕЗ-ийн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын батлагдсан төлөвлөгөө 36044.6 сая төгрөг, гүйцэтгэлээр 35824.9 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төлөвлөгөөнөөс 219.7 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан байна. Үүнд:

Эрүүл мэндийн салбарын байгууллагууд. Төв аймгийн Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг 27 байгууллагаас 6 байгууллагад итгэл үзүүлж 21 байгууллага санхүүгийн аудитад хамрагдсанаас 15 байгууллага нь зөрчилгүй санал дүгнэлттэй, Батсүмбэр, Баян-Өнжүүл, Дэлгэрхаан, Өндөрширээт гэсэн 4 сумдын ЭМТөвүүдэд хязгаарлалтай санал дүгнэлт өгч ажилласан. Аудитаар нийт 495.9 сая төгрөгийн алдаа, зөрчилд 106.6 сая төгрөгийн алдааг залруулж зөрчлийг таслан зогсоох 10.1 сая төгрөгийн төлбөрийн акт бичигдэж 200.8 сая төгрөгийн албан шаардлага өгөгдлөө.

Боловсролын салбарын байгууллагууд. Төв аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн 29 байгууллага, СӨБ-ийн 31 байгууллага, Хувийн хэвшлийн 4 цэцэрлэг, 1 сургууль нийт 65 байгууллага санхүүгийн тайланд аудит хийгдэхээс хувийн хэвшлийн 5 байгууллага аудитад хамрагдаагүй. Ерөнхий боловсролын сургуулиудын 11 сургуульд итгэл үзүүлсэн ба Жаргалант, Аргалант, Сэргэлэн, Зуунмод сумын 5-р сургууль, 4-р сургууль зэрэг 5 сургуульд хязгаарлалтай дүгнэлт өгч 13 сургуульд зөрчилгүй дүгнэлт өгсөн.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудаас Баянчандмань, Аргалант, Баян, Лүн, Эрдэнэ, Ирээдүй цогцолбор, Бүжинхэн цогцолбор цэцэрлэг зэрэг 7 цэцэрлэгт хязгаарлалтай санал дүгнэлт өгч, 12 цэцэрлэг зөрчилгүй дүгнэлт, 12 цэцэрлэгт итгэл үзүүлсэн.

Боловсролын байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитаар мөнгөн хөрөнгөтэй холбоотой нийт 315.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 182.1 сая төгрөгийн алдааг залруулж, зөрчлийг таслан зогсоох 22.3 сая төгрөгийн төлбөрийн акт бичигдэж 1386.9 сая төгрөгийн албан шаардлага өгөгдлөө.

Соёлын салбарын байгууллагууд. Төв аймгийн соёлын салбарын 31 байгууллагаас 14 байгууллагад итгэл үзүүлж 17 байгууллага аудитад хамрагдсанаас 12 байгууллагад нь зөрчилгүй санал дүгнэлт, Өндөрширээт сумын соёлын төв, Баянжаргалан сумын соёлын төв, Сэргэлэн сумын соёлын төв, Биеийн тамир, спорт бэлтгэл сургалтын төв, Монгол туургатан театрт хязгаарлалтай санал дүгнэлт өгч ажилласан. Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 220.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч 201.7 сая төгрөгийн алдааг залруулж, зөрчлийг таслан зогсоох 5.2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 13.5 сая төгрөгийн албан шаардлага бичигдсэн.

ТЗШ-ийн байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлөөс дурдвал:

- Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 10 цэцэрлэгийн тавилга тоног төхөөрөмжийн шинэчлэлд 75.0 сая төгрөг батлагдсаныг Аймгийн засаг даргын 438 тоот захирамжаар зориулалтыг нь өөрчилөн зөөлөн эдлэл, хичээлийн хэрэглэгдэхүүн нийлүүлэхээр БОНН ХХК-тай шууд гэрээ хийж гэрээний дагуу бараа ажил үйлчилгээ бүрэн нийлүүлэгдээгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16.5.6, 24.4, 42.7, 39.1, 39.2, 60.3.1, 60.3.6 гэсэн заалтуудыг зөрчин 32.7 сая төгрөгийн ажил хийгдээгүй байна.
- БСШУЯамнаас ирсэн 856.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар тараагдсан тавилга эд хогшил, тоног төхөөрөмж, бараа материалыг яамнаас зарим сумдад шууд нийлүүлэгдсэн, зарим нь Боловсролын газраар дамжин нийлдүүлэгдсэн боловч тэдгээрийн хоорондын тооцоог нийлж тулган баталгаажуулагдахгүй байна.
- БСШУЯамнаас авьяас хөтөлбөрийн хүрээнд хичээлийн хэрэглэгдэхүүн /ХА-2014.04.04/ 48.0 сая төгрөг Боловсролын газрын нэмэлт дансаар дамжин ирж

сумдын СӨБ-ийн нэмэлт дансаар дамжуулан Өмнө-говь аймгийн Далан ахан дүүс ХХК-д мөнгийг нь шууд шилжүүлж хүүхдийн тоглоом, зарим мөнгийг нь цэцэрлэгийн эрхлэгчид бэлэнээр авч ном бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16.5.6, 24.4, 42.7, 39.1, 39.2, 39.5, ТБОНӨБАҮХАТХуулийн 8.4, 8.5, заалтуудыг зөрчсөн байна.

- Сумдын Эрүүл мэндийн төвүүд нь аймгийн Эрүүл мэндийн газраас үнэ төлбөргүй өгсөн 154.9 сая төгрөгийн эм, вакцин, төрөл бүрийн оношлуурууд, ном зэрэг хөрөнгүүдийг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан төсвийн байгууллагад мөрдөгдөх “Нягтлан бодох бүртгэлийн заавар, журам”-ыг зөрчсөн байна.
- ССАЖГазар нь 2014 онд гаргасан киноны орлогоо өөрийн дансанд тусгаагүй мөнгөн гүйлгээний тайланд тайлагнаж кассын үлдэгдлээр тайлагнаагүй байна. Байгууллагын үйл ажиллагаа явуулж байгаа байр нь аймгийн Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтсийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байгаа тул ССАЖГазрын 2014 оны халаалтын зардал төсөвт суугдаагүйн улмаас 63.0 сая төгрөгний дулааны өр ХГБХэлтсийн баланс дээр тайлагнагдаж байна.
- ССАЖГазрын дансанд бүртгэлтэй Дүнжингарав соёл урлагын ордны 2013, 2014 оны халаалтын төсөв суугдаагүйн улмаас 105.1 сая төгрөгийн өр үүссэн. Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам 6-д заасан бэлэн мөнгө авах дээд хязгаараас хэтрүүлэн нэг удаагын авалтаар бэлэн мөнгө 2.2-466.1 сая төгрөгийг авч журам зөрчигдсөн байна.
- Биеийн тамир бэлтгэл спортын төв нь 2014 оны 03 сард Увс аймагт болсон өсвөр үеийн цаны улсын аварга шалгаруулах тэмцээнд бэлнээр гаргасан 1.3 сая төгрөгийн 0.9 сая төгрөг нь шатахуунд зарцуулагдсан бөгөөд тус шатахууны зардлын гүйцэтгэлийг бараа материалын тайлангаар дамжуулаагүй үр дүнгийн тайланд биеийн тамир уралдаан тэмцээний зардлаар тайлагнасан байна.
- Монгол туургатан театр нь ССАЖГазраас үзвэрийн үнэнд 1.8 сая төгрөгийг, аймгийн Засаг даргын нөөц сангаас түрээсийн төлбөрт 0.1 сая төгрөгийн орлогыг бэлнээр авсан боловч бүртгэл тайланд тусгаагүй байна. Тайлант онд Өөрийн орлогын төлөвлөгөөгөөр 34.2 сая төгрөг, гүйцэтгэлээр 13.3 сая төгрөгийн орлого оруулж төлөвлөгөөг 20.9 сая төгрөгөөр тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.4. Бусад төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудит.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 408 тоот тушаалаар батлагдсан 2014 оны санхүүгийн тайланд аудит хийх хуваарийн дагуу Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу улсын төсвийн шууд захирагчийн 38 байгууллагын санхүүгийн тайлангийн аудитыг СТАУС программаар гүйцэтгэн хянан, удирдаж тайланг 2015 оны 2 дугаар сарын 25-ний дотор ҮАГазарт файлаар бүрэн илгээсэн. Их монгол хөлөг ХХК-тай байгуулсан гэрээний дагуу Зуунмод, Эрдэнэ, Заамар, Баянчандмань сумдад байршилтай МСҮТөвийн санхүүгийн тайланд аудит хийсэн дүгнэлт тайланг хянаж ҮАГазарт хүргүүлэн ажиллаа.

Улсын төсвийн байгууллагуудаас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөхөөс татгалзсан санал дүгнэлт, Зуунмод сум дах Улсын нөөцийн салбар, Цээл сум дах Улсын нөөцийн салбар гэсэн байгууллагуудын санхүүгийн тайланд хязгаарлалттай санал дүгнэлт өгч, бусад байгууллагын хувьд зөрчилгүй санал дүгнэлт өгөгдсөн.

- Цээл сум дах Улсын нөөцийн салбар нь Төсвийн тухай хуулийн 6.4.4, 16.5.5, 42.2, 42.2.3, 42.7-д заасан заалтуудыг зөрчиж хөрөнгө бэлтгэх зөвшөөрөл, гэрээ байхгүй байгууллагын дарга нь өөрийн хувийн эх үүсвэрээр блокны машин авч төсвийн хөрөнгөөр цемент авч, түр ажилтан цалинжуулж, ажиллагсдаар блок хийлгэж хашаа, хаалга, харуулын байр хийсэн, хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй нь санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Аудитаар илэрсэн зөрчил нь материаллагын урьдчилан тогтоосон түвшингээс хэтэрсэн тул Хязгаарлалттай санал дүгнэлт өгсөн.
- Зуунмод сум дах Улсын нөөцийн салбар нь санхүүгийн тайлангийн тодруулгыг /УСНББОУС 1- Санхүүгийн тайлангийн толилуулга/ –ийн дагуу хийж ирүүлээгүй, Бараа материалын тайлангийн үлдэгдлийг журнал, тооллогын бүртгэл, тооцоо бодсон акттай тулган шалгахад санхүүгийн тайлангийн дүнгээс бичиг хэргийн материал, аж ахуйн материал, тусгай зориулалттай бараа материал, бусад материалын тооллогын бүртгэл байхгүй, 3.8 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь санхүүгийн тайлангийн “толилуулга ба илчлэл”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна. Аудитаар илэрсэн зөрчил нь материаллагын урьдчилан тогтоосон түвшингээс их тул Хязгаарлалттай санал дүгнэлт өгсөн.

2.5. Санхүүгийн аудитын тайлагналын дараах үе шатны ажил болон завсрын аудит

2014 оны санхүүгийн тайлангийн аудитаар эрсдэлтэй байж болох дараагийн аудитаар авч үзэхээр тодорхойлсон аудитын тайлагналын дараах үе шатны ажлыг Төв аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын тушаалаар батлан хэрэгжүүллээ. Үүнд:

Төв аймгийн Эрүүл мэндийн газар, 119-р цэргийн анги, Зуунмод сумын 4.5-р сургууль, Бүжинхэн, Ирээдүй цэцэрлэг, БОГазар, сум дундын Ойн анги, ТЕЗ-ын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн төрийн сангийн хэлтэс данс, Хувиарлагдаагүй данс, Баянхошуу жишиг хороололын хашааны худалдах, худалдан авах гэрээ хийгдсэн болон гэрээ хийгдээгүй батламж авсан айлуудын тооцоо, 2013 онд олгосон өвс тэжээл бэлтгэхэд олгосон 95.7 сая төгрөгийн тооцоо, Алтан намар арга хэмжээний билетний тооцоо, Байгаль хамгаалах сангаас 27 сумын нэрэмжит ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн байгуулах зорилгоор “100-Зуунмод” төсөл хэрэгжүүлэх ажлын гүйцэтгэл хамрагдсан. Аудитын тайлагналын дараах үе шатны ажлыг батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэн тайланг холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлэн хэрэгжилтийг тооцон ажиллаа.



Төв аймгийн Аудитын газрын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 10 сумын төсвийн байгууллагууд болон улсын төсвийн 8 байгууллагын санхүү бүртгэл, дотоод хяналтын үйл ажиллагаанд завсрын аудитыг хийхээр төлөвлөсний дагуу аудитыг бүрэн хийлээ. Үүнд: Сэргэлэн, Алтанбулаг, Баянцогт, Баянхангай, Баян, Баянцагаан, Угтаал, Заамар, Сүмбэр, Цээл зэрэг 10 сумдад болон аймгийн Нэгдсэн эмнэлэг, Хорих 415-р анги, Хөдөлмөрийн хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Хот тохижуулах газар,

Нийгмийн даатгалын хэлтэс, Стандарт хэмжил зүйн төв, Онцгой байдлын газрын санхүүгийн үйл ажиллагаанд хийлээ.

Завсрын аудитад хийгдсэн нийт 10 сумын ИТХурал, ЗДТГазар, сургууль, цэцэрлэг, соёлын төв, эрүүл мэндийн төв, тусгай зориулалттай сангууд зэрэг 60 төсөвт байгууллагууд, 65 тусгай зориулалттай сангуудын үйл ажиллагаа хамрагдсан. Завсрын аудитаар сумдын 3 шатны төсвийн орлогын бүрдүүлэлт, нягтлан бодох болон анхан

шатны бүртгэл хөтлөлт, тайлан гаргалт тооцоо бодолт, баримтын бүрдүүлэлт, хөрөнгийн ашиглалт хамгаалалт, тооллого, тооцоо бодолт, дотоод хяналт шалгалт, шилэн дансны хэрэгжилт, өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт зэргийг батлагдсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу шалгасан. Завсрын аудитын тайланг бичиж ажиллагсдын хуралд танилцуулсан ба дараах зөрчил дутагдал илэрсэнд зөрчлийг арилгуулахаар зөвлөмж өгч ажилласан. Үүнд:

- Улс, аймаг, суманд төвлөрүүлэх төсвийн орлогын төлөвлөгөөг зарим сумд нь нэр төрлөөр, дүнгээр тасалсан
- Төсөвт байгууллагуудын болон тусгай зориулалттай сангуудын санхүүгийн тайлангуудыг цаг хугацаанд нь гаргаагүй, гаргасан байгууллагын дарга, нягтлан бодогч нар нь гарын үсэг зурж албажуулаагүй
- Санхүүгийн тайланг үнэн зөв тайлагнаагүй зөрүүтэй буруу бичилт хийгдсэн, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл болон авлага өглөгийг данс бүртгэлд бүрэн тусгаагүй
- Хөрөнгийн буюу бараа материалын тооллого хийгдсэн боловч тооцоог бодож үр дүнг тайлагнаагүй
- Дотоод хяналт шалгалтын тайлангийн дагуу илэрсэн зөрчлийг арилгах талаар арга хэмжээг авч ажиллаагүй
- Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй
- Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт хангалтгүй зэрэг.

Аймгийн Нэгдсэн эмнэлэг

Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь Шилэн дансны мэдээлэл хүргэх хэлбэр, цаг хугацаа, албан тушаалтныг үүрэгжүүлэн ажилласан сайн талтай боловч үйл ажиллагааны орлого 9.3 сая төгрөгөөр буюу 11.2 хувиар тасарсан, ТБОНӨТХууль, НББТХууль болон Нягтлан бодох бүртгэлийн бодлого, баримт эргэлтийн графикайн дагуу анхан шатны баримтын бүртгэл хөтлөлт цаг хугацаандаа хийгдэхгүй байгаас эм болон хүнс бараа материалын тайлангийн тооллого тооцоо бодолтыг цаг хугацаанд хийж хяналт тавьж хэвшээгүй, улирлын тайлангаар тооцоо нийлсэн актыг бүрэн үйлдэж хэвшээгүй байгааг дүгнэлтэнд оруулан ажил сайжруулах талаар 7 зөвлөмж өгсөн.

Хот тохижуулах газар

2015 онд батлагдсан төлөвлөгөөгөөр удирдах ажилтан 1, гүйцэтгэх ажилтан 5, үйлчилгээний ажилтан 29, нийт 35 орон тоо батлагдсан байна. Гүйцэтгэлээр удирдах нийт 41 орон тоотойгоор ажиллаж 6 орон тоо илүү ажилласан байна. Энэ нь батлагдсан орон тооноос гүйцэтгэх 3 ажилтан, үйлчилгээний 3 ажилтан илүү ажиллаж байна. Тээврийн хэрэгслийн ашиглалтын байдлыг шалгахад 14 тээврийн хэрэгсэл дансанд бүртгэлтэйгээс, 8 тээврийн хэрэгсэл бүрэн ашиглагдаж, 3 тээврийн хэрэгсэл биетээр байхгүй, 3 тээврийн хэрэгсэл эвдэрсэн ашиглалтгүй байна.

Автотээврийн хэрэгслийн хувийн хэргийг шалгахад өөрийн эзэмшилд байгаа тээврийн хэрэгслээс 7 тээврийн хэрэгсэлд хувийн хэргийг нээж хөтөлсөн, 5 тээврийн хэрэгсэлд хувийн хэргийг нээж хөтлөөгүй байна. Дээрх хувийн хэрэгт шинээр тавигдсан сэлбэгүүдийг 2014 оныг дуустал бичиж тэмдэглэсэн, тээврийн хэрэгслийн нийт явсан км болон зарцуулсан шатахууныг бичээгүй байсныг цаашид бүрэн хөтлөх талаар аудитаар зөвлөмж өгсөн

Хорих 415-р анги

Хорих 415-р анги нь 2015 оны эхний 9-н сарын байдлаар 61.2 сая төгрөгийн өөрийн орлого төвлөрүүлсэнээс дотоод орлого 40.6 сая төгрөг, мал аж ахуйгаас 5.3 сая төгрөг, хоригдол ажиллуулсаны орлого 7.1 сая төгрөг, эргэлтийн орлого 2.7 сая төгрөг, шугам ашиглуулсаны орлого 1.0 сая төгрөгийн орлого тус тус төвлөрүүлсэн байна.

Хорих 415-р ангийн барилга, байгууламжийн чанар байдал дунд зэрэг байсныг засварлан өөрчлөлт хийж хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, ашиглалтын хугацааг уртасгах талаар анхаарч олон зүйлийг хийж тохижуулсан байна. Тус анги нь нэг цэгийн үйлчилгээний барилгыг шинээр барьж ашиглалтанд оруулсан, соёлын төвийн барилгыг

ажилчдын орон сууцны зориулалтаар засварласан зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэснийг зохих журмын дагуу байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэж авах мөн зориулалтыг өөрчлөн засварласан барилгыг үнэлж бүртгэх талаар зөвлөмж өглөө.

Хөдөлмөрийн хэлтэс

Хэлтсийн эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн үр дүн, мөнгөн гүйлгээний өмнөх оны үзүүлэлт байхгүй, Магнай трейд ХХК-аас 1852.5 мянган төгрөгийн шатахуун авсныг бараа материалын тайлангаар тайлагнаагүй шууд зардалд бичиж тайлагнасан. Нэмэлт санхүүжилтийг мөнгөн суурьт шалгах балансад салгаж тайлагнаагүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санг шалгахад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын мөнгөний 80 хувийг сургалт явуулаагүй байхад урдчилан шилжүүлсэн, ХЭДСангийн тухай хуулийн 8.3-т ЕБС-ийн ахлах ангийн сурагчид ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг тухайн сургуулийн захиргаатай хамтран тусгайлсан төлөвлөгөөний зохион байгуулна. гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 14.2-т нийтийг хамарсан ажлын хөтөлбөрийг аж ахуй нэгж, төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулна. гэсэн заалтыг мөрдөн ажиллаагүй байна.

Нийгмийн даатгалын хэлтэс

Нийгмийн даатгалын хэлтсийн мөнгөн гүйлгээний тайлангийн “бусдаас” гэсэн ангилалд 13505.9 мянган төгрөгийн орлого бүртгэсэн нь байцаагчдын маягтын авлага бууруулах бичилтийг орлогоор буруу бүртгэсэн. Нийгмийн даатгалын хэлтэс нь орон тооны нярав байхгүй бичиг хэргийн ажилтанд давхар хариуцуулан дотоод хяналт, хөрөнгө хариуцсан ажилтан гэсэн орон тоо ажиллуулж байна. Тухайн ажилтан нь бичиг хэргийн материал, аж ахуйн материал, түлш шатах, тослох материал, маягтын тайлангуудыг сар бүр, Үндсэн хөрөнгийн 6 дансны тайланг хагас бүтэн жилээр хугацаанд тайлан гаргаж өгдөг боловч тооцоо боддоггүй зөрчил давтагдсаар байна. Тооллогын комисс нь тооллогын бүртгэлийн НХМаягт БМ-8-ийг хөтлөөгүй, тооллогын бүртгэл, тооцоо бодсон актын алин болох нь ойлгомжгүй маягтаар бүртгэлийг компьютерт шивж гарын үсэг зурсан, хөрөнгийн чанар байдал тэмдэглээгүй, тайлбарт эзэмшигчийн нэрийг бичсэн байна.

Онцгой байдлын газар

Эхний 8 сарын байдлаар батлагдсан төлөвлөгөөгөөр 491753.3 мянган төгрөг, гүйцэтгэлээр 479831.1 мянган төгрөг зарцуулж, 11922.2 мянган төгрөгөөр төсвийг хэмнэлттэй зарцуулсан. Төсвийн хэмнэлтийн 11802.2 мянган төгрөг буюу 98.9 хувийг цалин хөлс, болон нэмэгдэл урамшуулалын зардал эзэлж байна. Цалингийн хэмнэлт ихээр гарч байгаа нь цалингийн зардлыг хэт өндөр баталсантай холбоотой байна. Тооллогын комисс нь тооллогын бүртгэлийн НХМаягт БМ-8-ийг компьютерт шивж гарын үсэг зурсан, хөрөнгийн чанар байдал, тайлбар зэрэгт ямар нэгэн тэмдэглээ хийгдээгүй өмнөх зөрчил бүрэн арилаагүй байсанд зөвлөмж өгч ажиллаа.

Улсын бүртгэлийн хэлтэс

2015 онд удирдах ажилтан 1, гүйцэтгэх ажилтан 38, үйлчлэх ажилтан 8, нийт 47 орон тоотой эхний хагас жилд 193071.6 мянган төгрөгийн цалингийн сантай батлагдсанаас 47 орон тоотой ажиллаж 192918.1 мянган төгрөгийн цалин олгосон байна. Ерөнхий дэвтэрт цалингаас суутгасан ХХОАТ-ыг 2339.8 мянган төгрөгөөр, НДШ 25.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгасан нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал, НББ-ийн тухай хуулийн 9.1 дэх заалтыг зөрчсөн байна.

Ашиглалтын зардалд 5529.6 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 6351.9 мянган төгрөгийн зардал гарч 848.1 мянган төгрөгийн өглөгтэй тайлагнасан байна. 1 сард халаалт, цэвэр бохир усны зардлыг 905.8 мянган төгрөгөөр ерөнхий дэвтэрт дутуу бичилт хийсэн байна.

Стандартчилал хэмжил зүйн хэлтэс

Тус хэлтэст 2015 оны эхний 5-н сарын байдлаар 73.5 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан бөгөөд гүйцэтгэлээр 71.7 сая төгрөгийн санхүүжилт авч батлагдсан

хэмжээнээс 1.9 сая төгрөгөөр буюу 2.5 хувиар дутуу санхүүжсэн байна. Эхний 5-н сарын байдлаар 1.9 сая төгрөгийн бараа, материалын орлого орж, 2.1 сая төгрөгийн зарлага гарсан байна. Үндсэн хөрөнгийн орлого байхгүй бөгөөд 6.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө акталсан байна. Төрийн өмчийн хорооны 2015 оны 1-р сарын 28-ний өдрийн 54 тоот тогтоолоор уг хөрөнгийг акталсан байна. Тус хэлтийн санхүүтэй холбоотой тайлан, мэдээ мэдээлэл нь ил тод, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу шаардлагын түвшинд илэрхийлэгдсэн байна.

2.6 Санхүүгийн тайлангийн аудитын мөрөөр авсан арга хэмжээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 34831.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 14123.3 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 9991.1 сая төгрөгийн албан шаардлага, 175.4 сая төгрөгийн төлбөрийн акт бичиж, зөрчлийг арилгуулахаар байгууллагын удирдлагуудад 616 зөвлөмж өгч ажиллаа. Төв аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2014 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг аймгийн ИТХТ-ийн хуралдаанд оруулан хэлэлцүүлсэн.

Санхүүгийн тайланд хязгаарлалттай санал дүгнэлт өгсөн болон ихээхэн хэмжээний зөрчил, төлбөр гаргасан нийт 48 албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар холбогдох байгууллага албан тушаалтанд албан шаардлага хүргүүлэн 43 албан тушаалтанд хариуцлага тооцуулсан.

Гурав. Гүйцэтгэлийн аудит

2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу УАГазрын нэгдсэн удирдамж төлөвлөгөөний дагуу 5 гүйцэтгэлийн аудит, аймгийн ИТХ-ын захиалгын дагуу 1 гүйцэтгэлийн аудитыг хийж гүйцэтгэлээ.

3.1 УАГ-ын нэгдсэн төлөвлөгөөгөөр хийсэн гүйцэтгэлийн аудит

3.1.1 Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан УАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, аймгийн Аудитын газрын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу **“Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн”**-д аудитыг 02 дугаар сарын 01-нээс 04 дүгээр сарын 15 хүртэл хугацаанд хийж гүйцэтгэн тайлан, судалгааг УАГ-т хүргүүллээ.

Төв аймаг нь 2014 онд “Монгол улсын 2014 оны төсвийн тухай хууль”-аар 7 сайдын багцаас нийт 9100.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 хөрөнгө оруулалт, их засварын ажилд 7450.4 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас 7439.4 сая төгрөгийн



санхүүжилт хийгдэж хөрөнгө оруулалтын ажлууд хэрэгжсэн байна. Цээл сумын ЗДТГазар, иргэний танхимын барилгын ажилд 350.0 сая төгрөг батлагдсанаас 339.0 сая төгрөг санхүүжиж 2014 онд улсын төсвөөс нийт дүнгээрээ 11.0 сая төгрөг дутуу санхүүжсэн байна.

Хөрөнгө оруулалтаар шинээр хийгдсэн 7927.5 сая төгрөгийн өртөгтэй 4 хөрөнгө оруулалт,

бүтээн байгуулалтын ажил нь Лүн сумын төвийн айл, өрх, албан байгууллагыг цэвэр, бохир, ус дулаанд холбох, цэвэрлэх байгууламж байгуулах /5000.0 сая төгрөг/, 3 сумын халаалтын зуух, дулааны шугам сүлжээ барих /1610.0 сая төгрөг/, Цээл сумын ЗДТГазар, иргэний танхимын барилгын ажил /837.5 сая төгрөг/, 0.4 квт-ын цахилгааны шугамын шинэчлэлийн /480.0 сая төгрөг/ ажлууд байна. 1833.4 сая төгрөгийн өртөгтэй 9 их засварын ажлууд байна.

Аймгийн төсвөөс 2014 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын эх үүсвэр нь:

- ✓ Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 166.0 сая төгрөг
- ✓ Орон нутгийн төсвийн урд оны шилжих үлдэгдлээс хөрөнгө оруулалтад 1382.3 сая төгрөг
- ✓ Авто замын санд 317.2 сая төгрөг
- ✓ Төсвийн хэмнэлтээс 474.6 сая төгрөг, нийт 2340.1 сая төгрөгөөр батлагдсан. Үүнээс 1839.2 сая төгрөгийг зарцуулжээ.

Аудитын явцад хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа, ажлын гүйцэтгэл, хөрөнгийн данс бүртгэлтэй холбоотой нийт 7212.5 сая төгрөгийн зөрчил илэрч, 21.2 сая төгрөгийн акт, 7191.3 сая төгрөгийн албан шаардлага бичигдэж, холбогдох байгууллага, албан тушаалтнуудад зөрчлийг арилгах зөвлөмжийг хүргүүлээ.

Аудитын явцад худалдан авах ажиллагаатай холбоотой илэрсэн зарим зөрчилүүдээс дурьдвал:

-Дэлгэрхаан сумын 149.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны ариун цэврийн байгууламжийг хийж гүйцэтгэх ажил нь хуулиараа сонгон шалгаруулалт явуулах байтал аймгийн Худалдан авах ажиллагааны албаны дарга албан бичиг явуулж, улмаар “Монгол дайван” ХХК-тай шууд гэрээ байгуулсан.

-Аймгийн зургаан сумдын 0.4 кв-ын шугамын өргөтгөл, шинэчлэлтийн 480.0 сая төгрөгийн өртөгтэй ажлын гүйцэтгэгчээр Гэгээн цайдам ХХК шалгарч 6 сумын 6 багцад гэрээ байгуулсан байна. Цээл, Сүмбэр, Заамар сумдад хийгдэх 225.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг 240.0 сая төгрөгөөр хийлгэхээр үнэлгээний хороо шийдвэрлэж гэрээ байгуулах эрх олгосон байна.

-Архуст сумын соёлын төвийн барилгын их засварын гүйцэтгэгчээр шалгарсан Людмила ХХК-ий тусгай зөвшөөрлийн хугацаа 2014 оны 06 сарын 10-нд буюу ажил гүйцэтгэх хугацаанд дуусч байгаа боловч аймгийн Худалдан авах ажиллагааны албаны дарга Э.Амарсайхан даргатай үнэлгээний хороо нь тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах талаар авсан арга хэмжээг шалгаж үзэлгүйгээр тендерт шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгосон байна.

-Баянчандмань сумын МСҮТ-ийн дээврийн засварын ажлын тендерт Эл Си Би ХХК шалгарч, 327.7 сая төгрөгийн өртөгтэй ажлыг 316.0 сая төгрөгөөр гүйцэтгэх гэрээ байгуулжээ. Гэтэл тендерийн эх баримт дахь тусгай зөвшөөрөл нь тус компанийнх биш “Өндөр жинст” ХХК-ны тусгай зөвшөөрөл байна.

Аудитаар Төсвийн тухай хууль, ТБОНӨХБАҮХАТухай хуулийг зөрчсөн зөрчилүүдийг арилгуулахтай холбоотой тодорхой арга хэмжээ зохион байгуулсан. Тухайлбал, гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлээгүй зарим компанийг Сангийн яамны тендерт оролцох эрхийг хязгаарлуулах жагсаалтанд оруулах саналаа ҮАГ-т хүргүүлсэн. Мөн худалдан авах ажиллагаанд ашиг сонирхолын зөрчил үүссэн байж болзошгүй гэж үзсэн албан тушаалтаны асуудлыг АТГ-т шалгуулахаар шилжүүлж, шалгуулан уг зөрчлийг дахин гаргахгүй байх тухай прокурорын тогтоол гаргууллаа.

3.1.2 Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, Аймгийн аудитын газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Төв аймгийн 2014 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл” –д аудитыг 2014 оны 05 дугаар сарын 01-нээс 05 дугаар сарын 11-ний богино хугацаанд хийлээ. Аудитыг 2014 оны төсвийн

гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайлан, судалгаа бусад баримт материалд тулгуурлан хийв.

Орлогын талаар: Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг батлагдсан төлөвлөгөөгөөр 10176.3 сая төгрөг, Тусгай зориулалтын шилжүүлэг 35939.1 сая төгрөгийг төлөвлөсөн хэмжээгээр бүрэн авсан байна. Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт 9618.2 сая төгрөгөөр батлагдсанаас, гүйцэтгэлээр 6890.8 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж, 2727.4 сая төгрөгөөр дутуу санхүүжигдсэн байна

Төв аймгийн 2014 оны төсвийн орлого, эх үүсвэрийг аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаас 69431.8 сая төгрөгөөр баталсан. Аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас орон нутгийн төсөвт төвлөрөх татварын орлогыг 1549.2 сая төгрөгөөр тодотгон баталснаар 2014 оны аймгийн урсгал төсвийн орлого нийт 11071.3 сая төгрөгөөр батлагдсан байна.

Төв аймгийн 2014 оны ТЕЗ-ийн орон нутгийн төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аймгийн урсгал төсвийн орлого гүйцэтгэлээр 13344.6 сая төгрөг, үүнээс татварын буцаан олголт 524.6 сая төгрөгийг хасч тооцоход 12819.9 сая төгрөгөөр тайлагнасан. Энэ нь батлагдсан төлөвлөгөөг 134.8 хувиар буюу 1748.6 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

ТЕЗ-ийн 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар төсөвт газрын өөрийн орлого 183.2 сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс, гүйцэтгэлээр 116.7 сая төгрөг орж, 66.5 сая төгрөгөөр дутуу буюу 64.0 хувийн биелэлттэй байна. Өөрийн орлогын төлөвлөгөөг Алтанбулаг, Баян-өнжүүл, Борнуур, Мөнгөнморьт, Угтаал сумдад 14.8 - 73.3 хувиар тасалсан байна.

Зарлагын талаар: Төв аймгийн ТЕЗ-ийн төсвийн 2014 онд зарцуулах зарлагыг аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаас нийт 68761.4 сая төгрөгөөр баталсан. Сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас оны эхний шилжих үлдэгдэл болон давсан орлогоос 19 суманд 670.4 сая төгрөгийг тодотгож, нийт 69431.8 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна.

ТЕЗ-ийн 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар төсвийн зарлагын гүйцэтгэл 75701.8 сая төгрөг зарцуулсан нь батлагдсан төлөвлөгөөнөөс 6263.9 сая төгрөг хэтэрсэн байна. ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын батлагдсан төлөвлөгөөг нэгтгээгүй нь зардлын хэтрэлтэнд нөлөөлсөн байна.

Сангийн яаманд Төв аймгийн ТЕЗ-ийн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар аудитлагдсан төсвийн зарлагын төлөвлөгөөг 68761.4 сая төгрөгөөр, зарлагын гүйцэтгэлийг 75760.1 сая төгрөгөөр өөрчлөн нэгтгүүлсэн байна.

Сангийн яам нь төсвийн зарлагын төлөвлөгөөнөөс сумдын ИТХурлаар тодотгон баталсан 670.4 сая төгрөгийг хасч, төсвийн зарлагын гүйцэтгэлийг төрийн сангийн данснаас нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулсан 36.3 сая төгрөгийн санхүүжилт болон орон нутгийн орлогын дансанд тусгай сангийн данснаас төвлөрүүлсэн 22.0 сая төгрөг, нийт 58.3 сая төгрөгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэмж тайлагнасан байна.

Төв аймгийн ТЕЗ-ийн төсвийн зарлагын гүйцэтгэлийг сайдын багцаар авч үзвэл нийт зарлагын 38.4 хувийг аймгийн Засаг даргын багц, 34.7 хувийг БСШУСайдын багц, 8.1 хувийг Эрүүл мэндийн сайдын багц зарцуулсан байгаа нь нийт зарлагын 81.2 хувийг эзэлж байна.

3.1.3 Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, Аймгийн аудитын газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу *“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт”* –д аудитыг 2015 оны 02 дугаар сарын 01-нээс 03 дугаар сарын 01-ны хугацаанд гүйцэтгэлийн аудитыг хийж Үндэсний аудитын газарт удирдамжийн дагуу судалгаа, тайлбар гарган хүргүүлсэн.

Төв аймгийн 2014 оны үндсэн чиглэлд 32 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч 14 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 17 арга хэмжээ хэрэгжих шатандаа, 1 арга хэмжээ хэрэгжээгүй гэж тооцоод 90.6 хувийн биелэлттэй дүгнэсэн байна.

2014 оны үндсэн чиглэлийн санхүүжилтийн эх үүсвэрийн төлөвлөлт 5868.0 сая төгрөг, гүйцэтгэл 5868.0 сая төгрөг байна.

Аймгийн ЗДТГ-аас ирүүлсэн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайлан мэдээ 90.6 хувийн биелэлттэй хэрэгжсэн гэж тайлагнасан нь аймгийн хэрэгжүүлэгч газрууд хэрэгжээгүй ажлыг хэрэгжсэнээр тооцох, хамтран хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээнд ажлын оролцоог зааглаагүй, дээд шатны байгууллагаас хэрэгжүүлсэн ажлыг өөрсдийн биелэлтээр тооцож дүгнэж байна.

3.1.4 Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, Аймгийн аудитын газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу *“Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан Ажилтай Монгол хүн, Эрүүл Монгол хүн хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн”* –д аудитыг 2014 оны 01 дүгээр сарын 15-наас 02 дугаар сарын 25-ны хугацаанд хийлээ. Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 154 дугаар тогтоолоор батлагдсан “Ажилтай орлоготой монгол хүн” /2012-2016/ үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2013 оны 86-р тогтоолоор “Ажилтай орлоготой Монгол хүн” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн байдлыг гүйцэтгэлийн аудит хийхэд аймагт хэрэгжүүлбэл зохих төлөвлөгөөний 21 арга хэмжээг 100 хувиар, 39 арга хэмжээг 90 хувиар, 9 арга хэмжээг 70 хувиар, 3 арга хэмжээг хугацаа болоогүй гэж нийт 90.4 хувийн биелэлттэй тайлагнасан байдлыг аудитын явцад газар дээр нь очиж холбогдох албан тушаалтнуудтай уулзаж зарим баримт материалыг шалгаж үзээд 5 арга хэмжээг 100 хувийн бүрэн хэрэгжилттэй, 31 арга хэмжээг 90 хувийн биелэлттэй хэрэгжиж байгаа, 24 арга хэмжээг 70 хувийн биелэлттэй болон хэрэгжиж байгаа, 6 арга хэмжээг 50 хувийн биелэлттэй хэрэгжиж эхэлж байгаа, 2 арга хэмжээг 30 хувийн биелэлттэй хэрэгжиж эхэлж байгаа, хугацаа болоогүй буюу хэрэгжиж эхлээгүй 4 арга хэмжээ байгаа нь нийт дүнгээрээ 74 хувийн хэрэгжилттэй байна. Гүйцэтгэлийн аудитаар хойшид батлагдсан хөтөлбөр төлөвлөгөөг цаг хугацаанд нь чанартай хэрэгжүүлэн биелэлтийг үнэн зөв, бодит байдалд тулгуурлан гаргах, дотоод хяналт шалгалтаа сайжруулах зэргээр хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмж өглөө.

Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Эрүүл чийрэг монгол хүн” /2012-2016/ үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд гүйцэтгэлийн аудит хийхэд аймагт хэрэгжүүлбэл зохих төлөвлөгөөний 5 арга хэмжээг 90 хувиар, 7 арга хэмжээг 70 хувиар, 5 арга хэмжээг 50 хувиар, 4 арга хэмжээг 30 хувиар биелүүлж нийтдээ 62.3 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байдлыг аудитын явцад газар дээр нь очиж шалгаж үзээд 2 арга хэмжээг 90 хувийн, 7 арга хэмжээг 70 хувийн, 5 арга хэмжээг 50 хувийн, 4 арга хэмжээг 30 хувийн, 1 арга хэмжээг 20 хувийн, 2 арга хэмжээг хэрэгжүүлж эхлээгүй байгаа нь нийт дүнгээрээ 50.5 хувийн хэрэгжилттэй байна гэж дүгнэлээ. Тус хөтөлбөр 2012-2016 онд Эрүүл мэндийн яам болон бусад яам, хууль эрх зүйн өөрчлөлтөөс шалтгаалан хэрэгжих хугацаа болоогүй, эхлэлтийн шатандаа явж байна. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үлдсэн хугацаанд хэрхэн ажиллах талаар арга зүйн зөвлөмж өгч ажиллаа.

3.1.5 Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, аймгийн Аудитын газрын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу *“Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүн”* –д аудитыг 08 дугаар сарын 20-ноос 11 дүгээр сарын 05 хүртэл хугацаанд хийж гүйцэтгэн тайлан, судалгааг ҮАГ-т хүргүүллээ. Уг аудитаар орон нутагт үйл ажиллагаа явуулж, барьцаа хөрөнгөө тухайн орон нутагт тусгай дансанд байршуулдаг хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 175 аж ахуйн нэгжийн 2013, 2014 онуудын үйл ажиллагааг хамрууллаа.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, зардал батлуулдаг боловч байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээх үүргээ биелүүлэхийн баталгаа болгон байршуулах мөнгөн хөрөнгийг байршуулдаггүй, мөн мөнгөн хөрөнгө байршуулаагүй тохиолдолд “Ашигт малтмалын тухай” хуулийн 39.6-д

заасны дагуу сум, дүүргийн Засаг дарга уурхайн тухайн жилийн олборлолтын ажлыг эхлүүлэхгүй байх эрхтэй гэсэн хуулийн заалтууд хэрэгждэггүй байна.



Орон нутагт хайгуулын үйл ажиллагаа явуулсан зарим аж ахуйн нэгжүүд байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн барьцаа мөнгийг сум, орон нутагт нь үлдээж, хандив маягаар өгдөг байна. Энэ мөнгийг сум орон нутаг хэрхэн зарцуулах, юунд зарцуулах нь эрх зүйн хувьд тодорхой зохицуулалтгүй явж ирсэн байна. Зарим тохиолдолд сум орон нутагт байгаль орчныг нөхөн сэргээж хүлээлгэн өгсөн акт үйлдээгүй байхад зөвхөн тухайн аж ахуйн нэгжийн

албан тоотоор буцаан олгосон байна.

Байгаль хамгаалах нөхөн сэргээлтийн барьцаа мөнгийг хуульд заасны дагуу буюу байгаль хамгаалах нөхөн сэргээлтэд зарцуулсан тохиолдол Төв аймагт 2013 оноос хойш гараагүй байна.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль хамгаалах, нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг тооцоход АМГазар болон аймгийн БОАЖГ-аас гаргаж ирүүлсэн нөхөн сэргээлтийн мэдээ, тайлан, акт, баримт материал нь хоорондоо зөрүүтэй байна.

Судалгаанаас харахад АМГазар нь зарим аж ахуйн нэгжийн нөхөн сэргээлтийг аймаг, орон нутаг актаар хүлээж аваагүй байхад нөхөн сэргээлт хийсэн гэж тоо, мэдээндээ оруулж дараа жилд олборлолт явуулах боломжийг бүрдүүлж байна

АМГазар болон аймгийн БОАЖГ-ын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, тайлан, мэдээний талаархи 2 жилийн судалгаанууд нь хоорондоо зөрүүтэй байгаа нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төлөвлөгөө, тайлан мэдээ буруу гардаг, түүнд тавих хяналт байдаггүйгээс хариуцлага тооцогддоггүй, төрийн захиргааны төв байгууллага болон орон нутаг дахь мэргэжлийн байгууллагын ажлын уялдаа холбоо байхгүйг харуулж байна.

Энэ нь “Ашигт малтмалын тухай” хуулийн 39.1.5, 39.1.7-д заасны дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөө, тайланг төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ, хуулбар хувийг аймаг, сум орон нутагт хүргүүлнэ гэсэн заалт хэрэгжихгүй байна.

Аудитаар нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө болон уг тусгай данстай холбоотой зөрчилд 3.0 сая төгрөгийн акт, 23.3 сая төгрөгийн албан шаардлага бичиж хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаа.

3.2.1 Аймгийн ИТХ-ын захиалга, аймгийн Аудитын газрын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу *“Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтын байдал”*-д гүйцэтгэлийн аудитыг 2013 он, 2014 он, 2015 оны эхний хагас жилийг хамруулан хийлээ.

Уг аудитаар Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн байдлаас үзэхэд аймаг, сумын ИТХ-аар “Төсвийн тухай” хууль болон “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”-ийн дагуу нэр төрлөөр орлогыг төлөвлөж, төвлөрүүлсэн байна. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний орлогыг жил бүр Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан хувь хэмжээнээс дутуу төлөвлөж, батлуулж ирсэн байна.

2012 онд аймгийн ИТХ-ын хуралдаанаар уг зардалыг 1161.1 сая төгрөгөөр баталсан нь хуульд заасан хэмжээгээр тооцсноос 133.8 сая төгрөгөөр дутуу тооцож баталсан байна. Гүйцэтгэлээр 1137.3 сая төгрөг тус санд төвлөрөх боломжтой байхад 637.9 сая төгрөг буюу 54.5 хувийг төвлөрүүлж, 528.2 сая төгрөгөөр буюу 45.5 хувиар дутуу төвлөрүүлсэн байна.

2013 онд аймгийн ИТХ-ын хуралдаанаар 932.2 сая төгрөгөөр баталсан нь хуульд заасан хувь хэмжээнээс 120.1 сая төгрөгөөр дутуу байна. Гүйцэтгэлээр 1263.5 сая төгрөг тус санд төвлөрөх боломжтой байхад 911.4 сая төгрөг буюу 72 хувийг төвлөрүүлж 352.1 сая төгрөгөөр буюу 28 хувиар дутуу төвлөрүүлсэн байна.

2015 оны эхний 6 сарын байдлаар аймгийн байгаль хамгаалах санд 99.0 сая төгрөг төвлөрөх ёстой бөгөөд 53.1 сая төгрөг буюу 54 хувийг төвлөрүүлж 45.9 сая төгрөгөөр буюу 46 хувиар дутуу төвлөрүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 03-р сарын 03-ны өдрийн 31 тоот тогтоолын хавралтаар баталсан Аймаг сумын байгаль орчныг хамгаалах санд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах, тайлагнах журмыг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 2012 онд орсон өөрчлөлт, үүнтэй холбогдон гарсан Засгийн газрын 2014 оны 43-р тогтоолтой уялдуулан өөрчлөх шаардлагатай байна. Энэхүү ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар баталсан журмын хэрэгжилт хангалтгүй байна.

Аймгийн ИТХ-аас батлагдсан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төсөл арга, хэмжээний зардлыг батлагдсан жагсаалтын дагуу санхүүжүүлсэн боловч зориулалтын дагуу зарцуулаагүй байна. Аудитын явцад тус сангийн хөрөнгөөр хийгдсэн төсөл, арга хэмжээтэй холбоотой дараахь зөрчлүүд илэрлээ. Үүнд:

-Зураг, төсөвгүй ажилд хөрөнгө батлах буюу тооцоо судалгаагүй, төсөв хийгджээ.

- Дэлгэрхаан суманд хийгдсэн хөрсний бохирдлоос сэргийлж, цэвэрлэх байгууламж барихад батлагдсан 60.0 сая төгрөг,
- Хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх "100-Зуунмод" төсөлд батлагдсан 139.0 сая төгрөг, бүгд 199.9 сая төгрөгийн 2 ажил зураг, төсөвгүй байна.
- Мөн Зуунмод сумын хэмжээнд орон сууц бүхий айл өрхүүдийн хэрэглээний цэвэр усыг тоолууржуулахад шаардагдах усны тоолуур, холбох хэрэгслийг нийлүүлэх ажлыг тэргүүлэх төсөвчин Л.Эрдэнэбаатар хийсэн байна. Уг төсөв нь ажлын зураггүй хийгдсэн бөгөөд зарим нэг бараа материалыг давхардуулж, зардлыг тооцсон нь ажлыг өндөр өртөгөөр гүйцэтгэх нөхцлийг бүрдүүлсэн байна.

Аудитын явцад мэргэшсэн төсөвчинтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулан уг ажлын төсвийг дахин хянуулж, үнэлгээ хийлгэхэд захиалагчийн өгсөн ажлын тоо, хэмжээнээс илүү материалыг төсөвт тусгасан, ажлын үнэлгээг буруу сонгосон зэрэг зөрчлүүд гарлаа. Тус ажлын төсөвт өртөг 109.4 сая төгрөг бөгөөд тэргүүлэх төсөвчин Л.Эрдэнэбаатарын хийсэн төсвөөс 68.2 сая төгрөгөөр бага байгаа бөгөөд ямар ч үндэслэл, тооцоо судалгаагүй, төсөв хийгдэж, худалдан авах ажиллагаа зохион байгуулагдсан байна.

Байгаль хамгаалах сангийн батлагдсан төсөв хэтрүүлэх буюу батлагдаагүй ажилд хөрөнгө зарцуулсан байна.

- Хог хаягдлыг ангилан ялгаж, дахин боловсруулах үйлдвэрийн парк байгуулах ажлын зураг, төсөв хийлгэх 20.0 сая төгрөг батлагдаж, батлагдсан төсвөөс 6.6 сая төгрөг хэтэрсэн
- Хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх "100-Зуунмод" төсөлд 139.0 сая төгрөг батлагдаж, сумд болон аж ахуйн нэгж байгууллагаас 16.0 сая төгрөг төвлөрч, нийт 155.0 сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэртэй ажилд байгаль хамгаалах сангаас 153.9 сая төгрөг, аймгийн ОНХС-аас 48.0 сая төгрөг, бүгд 201.9 сая төгрөг зарцуулагдсан бөгөөд батлагдсан төсвөөс нийт 46.9 сая төгрөг хэтрүүлж зарцуулсан байна. Мөн уг ногоон байгууламжийн газрын асуудал шийдэгдээгүй байна.
- 2015 онд аймгийн байгаль хамгаалах, нөхөн сэргээх сан нь 2 дансаар гүйлгээ хийгдэж, төсвийн хэмнэлт, үлдэгдлээс болон шинэ сум төслийн техник хяналтын зардлаас санхүүжүүлэхээр шийдвэрлэгдсэн төслийн нэгжийг санхүүжүүлсэн нь ЗГ-ын тогтоолоор батлагдсан байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмыг зөрчсөн байна.

Худалдан авалтыг ТБОНӨХБАҮХАТухай хуулийг зөрчиж зохион байгуулсан байна.

- Дэлгэрхаан суманд хийгдсэн хөрсний бохирдлоос сэргийлж цэвэрлэх байгууламж барихад байгаль хамгаалах сангаас 50.0 сая төгрөг, нийт 150.0 сая төгрөг батлагдаж, худалдан авалтыг аймгийн ХААА-ны даргын ирүүлсэн албан тоотын дагуу шууд гэрээ байгуулсан.
- Аймгийн ИТХ-ын тогтоолоор батлагдсан 139.0 сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэртэй хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх "100-Зуунмод" ажлыг хэрэгжүүлэхдээ 6 суманд 116.0 сая төгрөгийг хувааж шилжүүлсэн байна. Сумд руу шилжүүлсэн 116.0 сая төгрөг нь уг төсөлд бараа материал нийлүүлж буй компаниуд руу шилжиж, цэцэрлэгт хүрээлэнгийн ажилд зарцуулагдсан байна. Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8.5-д “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно” гэсэн заалт зөрчигдсөн байна.

Аудитаар 5 зөвлөмж, 70.0 сая төгрөгийн төлбөрийн акт, 224.3 сая төгрөгийн албан шаардлага бичигдэж, зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаа.

3.3 Гүйцэтгэлийн аудитын мөрөөр авсан арга хэмжээ

2015 онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар нийт 93.8 сая төгрөгийн 7 төлбөрийн акт тавьж, 23 албан шаардлагаар 7438.8 сая төгрөгийн зөрчил арилгуулах шаардлага бичиж холбогдох байгууллага, албан тушаалтануудад хүргүүлэн хэрэгжилтийг тооцон ажиллаа. Гүйцэтгэлийн аудитаар санхүүгийн үр өгөөж 9025.3 сая төгрөг бүртгэж, холбогдох газраар хүлээн зөвшөөрүүлээ.

Дөрөв. Нийцлийн аудит

2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу ҮАГазрын нэгдсэн удирдамж төлөвлөгөөний дагуу 4 нийцлийн аудитыг хийж гүйцэтгэлээ.

4.1 Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан нэгдсэн төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн нийцлийн аудит

4.1.1 Аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан нэгдсэн төлөвлөгөөний дагуу ҮАГ-ын Нийцлийн аудитын газартай хамтран *“Орон нутгийг хөгжүүлэх сангийн зарцуулалт”* –д аудитыг 2014 оны 02 дугаар сарын 01-нээс 06 дугаар сарын 01-ний хугацаанд хийлээ.

ОНХС-ийн сумдын харилцах данс нь оны эхэнд 970.8 сая төгрөг, аймгийн хөгжлийн сан 562.1 сая төгрөг, нийт 1532.9 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 6890.8 сая төгрөгийн санхүүжилт, хандив болон бусад орлогоор 1059.7 сая төгрөг, нийт 9483.4 сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлж, 8547.7 сая төгрөг зарцуулж, оны эцэст 935.7 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаас ОНХС-ийн эх үүсвэрийг сумдад 6184.5 сая төгрөг, аймагт 3433.7 сая төгрөг, нийт 9618.2 сая төгрөгийг зарцуулахаар тодотгон батласан, гүйцэтгэлээр сумдад 4520.3 сая төгрөг, аймагт 2370.5 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж, нийт санхүүжилтийн гүйцэтгэл 72 хувьтай байна.

2014 онд аймгийн хэмжээгээр 398 төсөл арга хэмжээнд 9618.2 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн боловч батлагдсан төсөл, арга хэмжээнээс 340 төсөл арга хэмжээ хэрэгжиж, 7581.4 сая төгрөг зарцуулагдсан байна. ОНХСангаас олгох санхүүжилт дутуу ирснээс 2014 онд аймгийн хэмжээнд 58 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна.

ОНХС-ийн орлого бүрдүүлэлттэй холбоотой дараахь зөрчил илэрлээ. Гүйцэтгэлээр аймгийн төсөвт газрын дуудлага худалдааны анхны үнэ 496.8 сая төгрөг төвлөрсний 332.3 сая төгрөгийг аймгийн орон нутгийн хөгжлийн санд хуваарилж, 164.5 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.



Аймаг, сумын ИТХ нь 2014 онд ОНХС-ийн хөрөнгөөр хийж гүйцэтгэх бараа, ажил, үйлчилгээний жагсаалт, түүнд зарцуулагдах хөрөнгийн эх үүсвэрийг батлахдаа хяналтын зураг, төсөвгүй ажилд хөрөнгө баталж, зарим өртөг өндөртэй ажлуудыг зураг, төсөвгүй хийж гүйцэтгэсэн байна. Үүнд: Дэлгэрхаан сумын ерөнхий боловсролын сургуулийн ариун цэврийн байгууламжийн төхөөрөмж суурилуулахад 150.0 сая төгрөг, Жаргалант сумын төмсний борлуулалтын сүлжээг сайжруулах, цардуулын

үйлдвэр байгуулах судалгаа шинжилгээний ажилд 150.0 сая төгрөг, Зуунмод сумын төвийг камержуулах 247.4 сая төгрөгийг зарцуулсан.

Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд ОНХС-аас зарцуулсан зураг, төсвийн үнийг зураг, төсөв гүйцэтгэсэн компанид илүү шилжүүлэх, гүйцэтгэгч компаниас суутгаж аваагүй зэрэг зөрчлүүд Эрдэнэ, Батсүмбэр, Цээл сумдад гарлаа.


Сумын ИТХ, багийн ИНХ-аар дэмжигдээгүй 172.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ хэрэгжсэн байна. Үүнд: Зуунмод, Сэргэлэн, Баянцогт, Мөнгөнморьт, Баянжаргалан, Эрдэнэ, Баян сумдууд байна.

Аудитаар нийт 3388.4 сая төгрөгийн зөрчил илэрч, 243.7 сая төгрөгийн төлбөрийн акт, 1079.2 сая төгрөгийн албан шаардлага бичигдэж, 2065.5 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэн зөрчлийг арилгуулан, акт, албан шаардлагын хэрэгжилтийг хангаж ажиллаа.

4.1.2 Аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан нэгдсэн төлөвлөгөөний дагуу УАГ-ын Нийцлийн аудитын газартай хамтран *“Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн”* –д аудитыг 2015 оны 08 дугаар сарын 23-нээс 09 дугаар сарын 23-ний хугацаанд хийлээ.

Дархлаажуулалтын сангийн талаар:

Дархлаажуулалтын сангийн үйл ажиллагаанд Үндэсний товллолт вакцинд хамрагдвал зохих хүний тоог бодитойгоор төлөвлөсөн, заавал хийх дархлаажуулалтаарх вакцины тарилгад хамрагдалт 97.1-99.2 хувийн хамрагдалтай сайн талтай боловч халдварт өвчин судлалын үндэсний төвд сайн дурын дархлаажуулалт, тархвар судлалын заалтаар болон урьдчилан сэргийлэх тарилгын захиалгыг ХӨСҮТөвд албан тоотоор хүргүүлээгүй, вакциныг төлөвлөх, нөөцлөх, бүртгэх журмын 1-ийн дагуу тооцож төлөвлөхдөө хангалтын тоо, тухайн нутаг дэвсгэрт вакцин хадгалах тоног төхөөрөмжийн хүчин чадал, вакцины үлдэгдлийг тооцоогүй, вакцин, биобэлдмэлийн хаягдлыг устгах журмын 4.2-д заасан устгалын актын 1 хувийг ХӨСҮТ-д хүргүүлнэ гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, актын нэг хувийг явуулж байгаагүйг дүгнэлтэнд оруулсан.



Вакцины орлогыг VSSM программд оруулахдаа ХӨСҮТ, ЗӨСҮТ-ээс ирсэн зарлагын падан дээрх нэг бүрийн үнийг зөв оруулж, эхэлж авсныг эхэлж зарлагдах аргаар тайлагнаж байх, ЭМСайдын 2011

оны 11-р сарын 07-ны 359-р тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Вакцин, биобэлдмэлийн хаягдлыг устгах журам”-ын 4.2-д заалтыг мөрдөж ажиллан устгалын акт хүргүүлсэн тухай бүртгэл хөтөлж байх, ЭМНХСайдын 1997 оны 219 тоот тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан вакциныг төлөвлөх, нөөцлөх, бүртгэх журмын 1-ийн дагуу тооцож төлөвлөхдөө хангалтын тоо, тухайн нутаг дэвсгэрт вакцин хадгалах тоног төхөөрөмжийн хүчин чадал, вакцины үлдэгдлийг тооцож ажиллах талаар зөвлөмж хүргүүлж ажиллаа.

Авто замын сангийн талаар:

2014 онд АТБӨЯХАТатвар нь төлөвлөгөөгөөр 257.2 сая төгрөг, гүйцэтгэлээр 237.9 сая төгрөгийн биелэлттэй гарч, замын санд 214.2 сая төгрөг, албан журмын даатгагчдын холбоонд 23.7 сая төгрөг төвлөрүүлэхээр байжээ.

Аймгийн ИТХ-аас АТБӨЯХАТатварын 10 хувь буюу 25.7 сая төгрөгийг жолоочийн хариуцлагын даатгалын санд төвлөрүүлэхээр баталсан байна. Албан журмын даатгагчдын холбоонд уг төлбөрийг шилжүүлэхдээ АТБӨЯХАТатварын орлогын гүйцэтгэлээс тооцолгүй төлөвлөсөн 257.2 сая төгрөгийн орлогоос тооцон 1.9 сая төгрөгийг илүү шилжүүлсэнд төлбөрийн акт бичив.

Аймгийн СТСХэлтэс нь Замын санд 214.2 сая төгрөг төвлөрүүлэхээс 247.2 сая төгрөг шилжүүлж, 33.0 сая төгрөгийг илүү шилжүүлсэнд давтан гаргахгүй байхыг анхааруулж албан шаардлага бичив.

Засгийн газрын 1998 оны 149 дүгээр тогтоолоор баталсан “Авто замын санг төлөвлөх, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-ын 14-р зүйлд заасан “... автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг 3 хоногт багтааж улсын болон орон нутгийн замын сангуудад шилжүүлэх ажлыг Сангийн яам хариуцна” гэсэн заалт нь орон нутагт хэрэгжээгүй байна. Аймгийн ИТХ-аар замын сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын жагсаалтыг батлахдаа Зуунмод хотын Жишиг хорооллын авто замын ажилд 80.0 сая төгрөг, Зуунмод хотын 1000 айлын орон сууцны авто зам, талбайн тохижилтод 55.0 сая төгрөг, нийт 135.0 сая төгрөгийн ажил зураг, төсөвгүй батласан байна. Энэ нь ЗГ-ын 1998 оны 149 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Авто замын санг төлөвлөх, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-ын 5-д “батлагдсан зураг төсөвтэй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна. Мөн авто замын сангаас орон нутгийн замын сан төвлөрүүлэх ажлын зардалд 5.0 сая төгрөг батласан нь уг журмыг зөрчсөн байна.

2014 онд авто замын сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр 6 ажилд 291.5 сая төгрөг батлагдсны 251.5 сая төгрөгийн 4 ажил нь хөрөнгө оруулалтын ажил байна. Эдгээр ажлуудаас Зуунмод хотын Жишиг хорооллын авто замын 80.0 сая төгрөгийн ажил хийгдээгүй бөгөөд Сүмбэр сумын гүүр барихад 30.0 сая төгрөгийг зарцуулж, сумын Засаг даргад эрх шилжүүлж гүйцэтгүүлсэн байна.

Аудитын явцад худалдан авалт болон сонгон шалгаруулалттай холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Аймгийн Засаг даргын захирамжаар авто замын сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулсан байна. Гэвч сонгон шалгаруулалт явуулах ажлын хэсгийн хурлын тэмдэглэл, үнийн санал ирүүлэх тухай албан бичиг, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан тухай хурлын шийдвэр зэрэг худалдан авалттай холбоотой бичиг баримт байхгүй байна.



Зуунмод хотын 1000 айлын орон сууцны авто зам, талбайн тохижилтод 55.0 сая төгрөг батлагдсан боловч 135.0 сая төгрөг зарцуулсан бөгөөд Зуунмод хотын Жишиг хорооллын авто зам, талбайн тохижилтод зарцуулахаар батлагдсан 80.0 сая төгрөгийг уг ажилд зарцуулсан байна. Энэ нь “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 3.25-д

“Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийн зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөх, батлагдсан төсөвт өртөг хэтрүүлэн тендер зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэхийг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

- Мөн 135.0 сая төгрөгийн 1000 айлын орон сууцны авто замын ажлыг гүйцэтгүүлэхдээ далангийн ажил, замын ажил гэж 2 хуваасан нь нээлттэй тендер шалгаруулалтаас зайлсхийсэн буюу ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 8.4-т “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”, 8.5-д “энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно” гэсэн заалт зөрчигдсөн байна.
- 2014 онд зураг төсөвгүй батлагдсан 2 ажлын нэг буюу 1000 айлын орон сууцны авто замын ажлын зураг төсвийг “Классик роуд” ХХК-аар гүйцэтгүүлэх гэрээг 2014 оны 6 сарын 20-нд байгуулж, 9 сарын 2-ны өдөр 2269.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 1812 м урттай авто замын зураг төсөлд Барилга хөгжлийн төвийн магадлалын ерөнхий дүгнэлт гарсан нь “Төсвийн тухай хууль”-ийн 29.4-т “хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”, ЗГ-ын 1998 оны 149 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Авто замын санг төлөвлөх, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-ын 5-д “батлагдсан зураг төсөвтэй байх” гэсэн заалтууд зөрчигджээ.

Соёл урлаг хөгжүүлэх сангийн талаар:

Соёл, спорт аялал жуулчлалын яамны Соёл, урлагийг дэмжих сангаас дараах зардлуудыг санхүүжүүлсэн нь хуулиар тодорхойлогдсон зорилго, зорилттойгоо нийцэж байна. Үүнд:

- Соёл, урлаг хөгжүүлэх сангийн 15.3.8 “соёл, урлагийн ажилтан, уран бүтээлчдийн мэргэжил дээшлүүлэх сургалт-семинар зохион байгуулах, тэдгээрийг гадаад, дотоодод зохиогдох соёл, урлагийн арга хэмжээ, тэмцээнд оролцуулах” гэсэн заалтын дагуу Соёл, спорт, аялал жуулчлалын яамнаас 2014 оны 5-р сарын 20-ны өдрийн 2/1794 тоотын дагуу Төв аймагт 2014 онд төвийн бүсийн сургалтанд 6.0 сая төгрөгөөр санхүүжүүлсэн.
- Соёл, урлаг хөгжүүлэх сангийн 15.3.7 “соёл, урлагийн байгууллагад онцгой шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн материал худалдан авах” гэсэн заалтын дагуу Төв аймгийн Батсүмбэр сумын соёлын төвд нийт 28.0 сая төгрөгийн өртөгтэй кино үзвэрийн тоног төхөөрөмж, хяналтын камерын иж бүрэн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн байна.
- Соёл, урлаг хөгжүүлэх сангийн 15.3.4 “соёлын өв, түүх, соёлын дурсгалт зүйл, үндэсний соёл, урлагийг гадаад болон өөрийн оронд сурталчилсан кино, дуу авианы бичлэг хийх, ном хэвлүүлэх, соёл, урлагийн мэргэжлийн сонин, сэтгүүл гаргахад дэмжлэг үзүүлэх гэсэн заалтын дагуу Төв аймгийн Нийтийн номын санд 1300.0 мянган төгрөгөөр “нийгэмд номын сангийн гүйцэтгэх үүрэг”, “ном уншихын ач тус” онол практикийн бага хуралд тавигдсан шилдэг илтгэлүүдээр 220 ширхэг ном хэвлүүлэхэд санхүүжигдсэн байна.
- Төв аймгийн Батсүмбэр сумын соёлын төвд 28.0 сая төгрөгийн өртөгтэй кино үзвэрийн тоног төхөөрөмж, хяналтын камерын иж бүрэн тоног төхөөрөмжийг 2013 онд хүлээлгэн өгсөн боловч тоног төхөөрөмжийг ажиллуулах мэргэжлийн хүнийг бэлтгээгүй, интернетийн орчин бүрдээгүйгээс кино үзвэрийн тоног төхөөрөмжийг огт ажиллуулаагүй, данс бүртгэлд тусгаагүй байсныг аудитын явцад албан шаардлага хүргүүлж данс бүртгэлд тусгуулсан.

Төв аймгийн Засаг даргын тамгын газрын төрийн сангийн хэлтсийн дэргэдэх 140051417 тоот соёл урлаг хөгжүүлэх сангийн данс 2013 оны жилийн эцэст 5.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй, 2014.01.24-нд нэг иргэнээс 0.1 сая төгрөгийн хандивын орлого тушаагдан 5.2 сая төгрөгийн эх үүсвэр бүрдэж, үүнээс 5.1 сая төгрөгийг сургалтын төлбөрт шилжүүлсэн байна.

Сургалтын төлбөрийг Төв аймгийн Засаг дарга, СУИС-ийн Бүжиглэх урлагын сургуулийн захирал, Төв аймгийн Монгол туургатан театрын дарга, Бүжиглэх урлагын сургуулийн сургалтын албаны дарга нар харилцан гэрээ хийж Бүжиглэх урлагийн сургуульд бүжгийн мэргэжлээр 3 оюутаныг суралцуулахаар 5.1 сая төгрөгийн төлбөрийг төлсөн боловч 2013 оны 9 сараас хойш гурвалсан гэрээг нэг ч удаа дүгнээгүй байна.

Төв аймгийн Засаг даргын захирамж нь Соёл, урлаг хөгжүүлэх сангийн 15.3.8 “соёл, урлагийн ажилтан, уран бүтээлчдийн мэргэжил дээшлүүлэх сургалт-семинар зохион байгуулах, тэдгээрийг гадаад, дотоодод зохиогдох соёл, урлагийн арга хэмжээ, тэмцээнд оролцуулах” гэсэн заалт, Аймгийн соёл, урлагийг хөгжүүлэх сангийн журмын 3.1.8 “соёл урлагийн ажилтан, уран бүтээлчдийн мэргэжлийг дээшлүүлэх, гадаад, дотоодод зохион байгуулах сургалт, семинар, соёл урлагийн арга хэмжээнд оролцуулах”, Төсвийн тухай хуулийн 42.7 “төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна. Уг аудитаар 3 зөвлөмж хүргүүлж ажиллаа.

4.1.3 Аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Монгол улсын Ерөнхий аудиторовн баталсан нэгдсэн төлөвлөгөөний дагуу УАГ-ын Нийцлийн аудитын газартай хамтран *“Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хэрэгжилт”* –д аудитыг 2015 оны 09 дугаар сарын 30-наас 10 дугаар сарын 15-ний хугацаанд хийлээ.



Нийцлийн аудитын газраас 2015 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр ирүүлсэн 2/1215 тоот албан бичгийн дагуу Төв аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулахаар “Эрчимжсэн мал аж ахуй”-н хөтөлбөрт хамрагдсан 7 аж ахуй нэгжийн зээлийн зарцуулалтанд шалгалт хийлээ. Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан аудитын төлөвлөгөө, асуудлын шинжилгээ, арга зүйн дэд түвшний 3-дугаар бүлгийн 3.2, 3.4-т заасан асуудлын хүрээнд тайланг бичиж УАГ-ын Нийцлийн аудитын газарт


хүргүүлээ.

Аудитад хамрагдсан 7 аж ахуй нэгжээс дэд хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлийг Хишигтэн нүүдэлчин ХХК, Зургаан хошуу ХХК-ууд нь зориулалтын дагуу зарцуулж үйл ажиллагаагаа явуулж байна. Хайрхан трейд ХХК нь үйл ажиллагаа нь эхлэж, Алтанмандал ХХК нь зээлийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх нь анхан шатны баримтаар нотлогдохгүй байна. Данзамд хайрхан ХХК, Мөнхийн Монгол ургац ХХК, Ноёнтуул ХХК-ууд нь үйл ажиллагаа явуулаагүй байна.

Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаанд ҮХААЯам, Мал аж ахуйн бодлого хэрэгжилтийг зохицуулалтын газар, Монгол банкнаас тус аж ахуй нэгжүүдэд шалгалт огт хийгдээгүй байна. Энэ нь гэрээний эрх үүргийн 2.1-д “хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрийн хүрээнд ерөнхий нөхцөл, хэрэгжүүлэх арга, чиг үүргийг тодорхойлж хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

4.1.4 Аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Монгол улсын Ерөнхий аудиторовн баталсан нэгдсэн төлөвлөгөөний дагуу УАГ-ын Нийцлийн аудитын газартай хамтран *“Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”* –д аудитыг 2015 оны 10 дугаар сарын 20-нээс 12 дугаар сарын 09-ний хугацаанд хийлээ.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд” гэсэн заалтын дагуу 230 байгууллага хамрагдахаас 5 байгууллага хамрагдаагүй, 10 сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээг гүйцэтгэж байгаа Шилэн дансны тухай хуулийн 3-р зүйлийн 3.1.4, 3.1.5-д заасан аж ахуйн нэгжүүд 6-р зүйлийн 6.9-д заасны дагуу мэдээллээ санхүүжилт хүлээн авсан төсөвт байгууллагын цахим хуудсанд байршуулаагүйг дүгнэлтэнд оруулан тайлагнасан.



“Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт нийцлийн аудитаар улс, орон нутгийн төсвийн байгууллага, орон нутгийн өмчит байгууллага, төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, төрийн өмчит хувьцаат компаниуд нь нийт 230 байгууллага байгууллагуудаас 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний санхүүжилт 1933.9 сая төгрөг, цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээ 1114.6 сая төгрөг, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого 18500.0 сая төгрөг, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэр 838.5 сая төгрөг, өр үүсгэсэн шийдвэрийн талаарх мэдээлэл 519.7 сая төгрөг, авлага үүсгэсэн шийдвэрийн талаарх мэдээлэл 206.9 сая төгрөг нийт 23113.6 сая төгрөгийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим сайт, байгууллагын вэб сайтад байршуулаагүй зөрчилд албан шаардлага өгсөн.

Мөн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн талаар ОНХС болон улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудын төлөвлөгөө, тэдгээртэй холбогдон гарсан шийдвэр, худалдан авалтын талаархи мэдээлэл, зарим хөрөнгө оруулалтын жагсаалт зэрэг холбогдох мэдээлэл хуульд заасны дагуу ороогүй, мэдээлэл тавих ажилтнууд нь хаана ямар мэдээлэл тавих, уг мэдээлэл нь нэгдсэн цахим хуудасны хаана, яаж мэдээлэгдэж байгаа талаар мэдэхгүй, шилэн дансны нэгдсэн портал системд тавьсан мэдээллийг хуулийн хугацаанд тавигдаж байгаа эсэх нь хэрэглэгчидэд харагдахгүй учир хяналт тавих боломжгүй, аудитын дүгнэлт, аудитын тайлан дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийг байршуулах цэс байхгүй мөн шилэн дансны нэгдсэн цахим хуудас нь өөрөө ойлгомжгүй байгаа талаар тайлагналаа.

“Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт нийцлийн аудитаар Аймгийн тусгай сангууд, Зуунмод мах боловсруулах ОНӨААТҮГ, Батсүмбэр суман дах Ойн анги, Мөнгөнморьт суман дах Ойн анги, Баруун-Зуунмод өрхийн эрүүл мэндийн төв, Хүүхэд залуучуудын соёл, спортын “Солонго” цогцолбор, Биеийн тамир, спорт бэлтгэлийн төв зэрэг байгууллагууд нь шилэн дансны нэгдсэн цахим сайт, байгууллагын вэб сайтад мэдээллээ байршуулаагүй тул сахилгын шийтгэл тооцуулахаар томилсон албан тушаалтанд албан шаардлага хүргүүлээ.

Шилэн дансны нэгдсэн портал системд мэдээлэл оруулах талаар арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллах, шилэн дансны нэгдсэн портал системд дутуу оруулсан мэдээллийг бүрэн оруулах талаар арга хэмжээ авч ажиллах, төрийн сангаас хийгдэж буй 5.0 сая төгрөгөөс дээш орлого зарлагын гүйлгээ, худалдан авалтын гүйлгээ, 10.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээг гүйцэтгэхэд төлсөн төлбөрийн гүйлгээг Шилэн дансны нэгдсэн портал системд холбох талаарх асуудлыг судалж шийдвэрлүүлэх зэрэг зөвлөмжийг хүргүүлж ажиллаа.

4.3 Нийцлийн аудитын мөрөөр авсан арга хэмжээ

2015 онд хийсэн нийцлийн аудитаар нийт 245.7 сая төгрөгийн 19 төлбөрийн акт тавьж, 25 албан шаардлагаар 24306.3 сая төгрөгийн зөрчил арилгуулах шаардлага бичиж

холбогдох байгууллага, албан тушаалтнуудад зөрчлийг арилгуулахаар 20 зөвлөмж өгч ажиллаа. Нийцлийн аудитаар ихээхэн хэмжээний зөрчил, төлбөр гаргасан нийт 17 албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар холбогдох байгууллага албан тушаалтанд албан шаардлага хүргүүлэн 10 албан тушаалтанд хариуцлага тооцуулсан. Мөн 6 албан тушаалтныг шалгуулахаар хууль хяналтын байгууллагад шилжүүлж 3 албан тушаалтныг тайлант хугацаанд шийдвэрлүүлсэн байна. Нийцлийн аудитаар 498.2 сая төгрөгний санхүүгийн, 27 санхүүгийн бус үр өгөөж бий болголоо.

Тав. Дотоод ажлын талаар

Төв аймгийн Аудитын газар нь 2015 онд удирдах ажилтны зөвлөлгөөнөөр дэвшүүлсэн төрийн аудитын байгууллагын зорилтын хүрээнд аудитын арга зүйгээ улам боловсронгуй болгох, аудитын үйл ажиллагаанд ашиглагдах программ хангамжийг сайжруулах, ҮАГ-тай нэгдсэн сүлжээгээр холбогдох зэрэг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн Тэргүүлэх аудиторовн тушаалаар батлан хэрэгжилтийг ханган ажиллаа.

Төрийн аудитын төв болон орон нутгийн байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөнд Төв аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан оролцсон. Аймаг нийслэлийн аудитын газрын үйл ажиллагааны үр дүнг үнэлэхэд 2014 оны үйл ажиллагаагаараа системийн хэмжээнд тусгай байр эзэлсэн.

Монгол улсын Ерөнхий аудиторовн “Оны шилдэг тайлан шалгаруулах” журмын дагуу “Газрын хууль тогтоомжийн хэрэгжилт” –д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан “Тэргүүн байр”-т шалгарч өргөмжлөл мөнгөн урамшуулалаар шагнагдлаа.

Монгол Улсын Ерөнхий аудитор А.Зангадтай Төв аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан үр дүнгийн гэрээ байгуулан, гэрээний биелэлтийг бүрэн хангаж А үнэлгээтэй дүгнэгдсэн.

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан журмын дагуу аймгийн аудитын газрын менежер нь аудитор шинжээч нартай 2015 оны үр дүнгийн гэрээг байгуулан, гэрээний биелэлтийг дүгнэлээ. Үр дүнгийн гэрээг дүгнэхэд А үнэлгээтэй 4, В үнэлгээтэй 7 албан хаагч дүгнэгдэж, үр дүнгийн урамшуулал олголоо.

Монгол улсын Ерөнхий аудиторовн “Оны шилдэг тайлан шалгаруулах” журмын дагуу “Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан”-д хийсэн санхүүгийн аудитын тайланг 5 үе шатны ажлын баримт материалын хамт ҮАГ-т хүргүүлсэн. Уг тайлан төрийн аудитын байгууллагын 2015 оны **тусгай байр** эзэлсэн 4 тайлангийн нэгээр шалгарсан байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2015 оны 18 тоот тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагын ажилтнуудаас авах мэргэшлийн шалгалтын журмын дагуу 2015 оны 12 дугаар сарын 16-наас 18-ны өдрүүдэд зохион байгуулсан Мэргэжлийн тестийн болон ур чадварын шалгалтанд хамрагдсан аудитын менежер О.Амаржаргал, ахлах аудитор Ц.Саранчимэг, шинжээч Ч.Бат-эрдэнэ нар онцсайн үнэлгээтэй шалгагдлаа.

Мэдээллийн ил тод байдлыг хангах талаар

- Төв аймгийн Аудитын газар нь 2015 оноос эхлэн Үндэсний аудитын газрын нэгдсэн вэб сайт болох www.audit.mn-д 2015 онд хийгдсэн 184 байгууллагын санхүүгийн аудитын тайлан, 6 гүйцэтгэлийн аудитын тайлан, 4 нийцлийн аудитын тайланг байршуулаад байна. Мөн байгууллагын цаг үеийн мэдээ, мэдээллийг байршуулан иргэд олон нийтийг мэдээллээр ханган ажиллаж байна.
- Төв аймгийн Аудитын газар гэсэн facebook хаяг нээж олон нийтэд мэдээллийг ил тод тавьж ажиллаа.

- Дотоод мэдээллийг “Lync” программаар дамжуулан аудитор, шинжээч нарт хүргүүлэн ажиллаа.
- Төв аймгийн төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж, байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд сар бүр хяналт тавьж зөвлөмж өгч, ҮАГ-т мэдээллэн ажиллаа.
- Байгууллагын санхүүгийн сар бүрийн мэдээг дараа сарын 2-ны дотор, улирлын тайланг дараа улирлын 20-ны дотор төрийн санд хүргүүлэн баталгаажуулан ажилласан. Байгууллагын санхүүгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн вэб сайт болон Үндэсний аудитын газрын вэб сайт, байгууллагын самбарт мэдээллэж ажиллаа.
- Аймгийн аудитын газрын албан тушаалтнуудаас хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэгийг гаргуулан авч, ХОМ-ийн тайланг Авлигатай тэмцэх тухай хуулийн дагуу 02 дугаар сарын 15-ны дотор ҮАГ-т хүргүүллээ.
- Төрийн ордны Их танхимд 2015 оны 5 дугаар сарын 14-ний өдөр зохиогдсон “Шилэн дансны тухай хууль”-ийн хэлэлцүүлэгт Төв аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан, аудитын менежер О.Амаржаргал нар оролцсон.

Ойн арга хэмжээний талаар

- Хөндлөнгийн хараат бус төрийн хяналтын байгууллага үүсэн байгуулагдсаны 20 жилийн ойн нэгдсэн арга хэмжээнд Төв аймгийн Аудитын газрын хамт олон амжилттай оролцлоо. Энэхүү арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдсан спортын төрөлд “Олс таталт” -аар 1 дүгээр байр эзэллээ.



Монгол улсад хөндлөнгийн хараат бус төрийн хяналтын байгууллага үүсч хөгжсөний 20-н жилийн ойг тохиолдуулан Төв аймгийн аудитын газар нь 2015 оны 11-р сарын 6-ны өдөр “Онол-практикийн бага хурал” хийлээ. Онол-практикийн бага хуралд аймгийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан “Төрийн аудитын тухай ойлголт, хөгжлийн чиг хандлага”, Аудитор Д.Пүрэвсүрэн

“Хөндлөнгийн хараат бус Төрийн Хянан шалгах байгууллага орон нутагт байгуулагдаж бэхжсэн нь” гэсэн сэдэвт илтгэлүүд тавилаа.

Хуралд Төв аймгийн удирдлагууд, аймгийн хяналт, шалгалтын байгууллагад ажиллаж байсан үе үеийн ахмадууд, хянан шалгах хорооны гишүүд болон хянан байцаагчаар ажиллаж байсан ажилтнууд, одоо төрийн аудитын байгууллагад ажиллаж буй ажилтнууд оролцлоо. Ойн үер аудитор Д.Пүрэвсүрэн Нягтлан бодох бүртгэлийн тэргүүний ажилтан, аудитор Ж.Бямбацогт, О.Сосор нар Санхүү банкны тэргүүний ажилтан, шинжээч Ч.Бат-Эрдэнэ Төрийн хяналтын тэргүүний ажилтан тэмдгээр шагнууллаа.

Төв аймгийн ИТХуралд оруулсан санал дүгнэлт

Төрийн Аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4-д аймгийн Аудитын газар нь “Орон нутгийн төсвийн төсөлд болон төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, орлого нэмэгдүүлэх талаар санал боловсруулж аймгийн ИТХуралд оруулах бүрэн эрхтэй” гэж заасны дагуу аймгийн орон нутгийн төсвийн төсөлд холбогдох тооцоо, судалгаа хийж аймаг, сумын төсвийн орлогыг 6 нэр төрөл дээр нийт 1767.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр санал орууллаа. Үүнд:



- Сумдын татварын орлогыг бууны албан татварыг 4.2 сая төгрөгөөр, хог хаягдлын хураамжийг 182.4 сая төгрөгөөр, нийт 186.6 сая төгрөгөөр

- Аймгийн төсвийн орлогыг Үл хөдлөх хөрөнгийн албан татварыг 49.1 сая төгрөгөөр, Ус ашигласны төлбөрийг 429.2 сая төгрөгөөр, Хөрөнгө борлуулсны орлогыг 520.0 сая төгрөгөөр, түрээсийн орлогыг 50.1 сая төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамжийг 32.2 сая төгрөгөөр,

нэр зааж ангилагдаагүй орлогыг 500.0 сая төгрөгөөр нийт 1580.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.

Албан хэрэг хөтлөлт, мэдээ мэдээллийн талаар

- Аймгийн аудитын газар нь Ерөнхий сайдын 2015 оны 124 дүгээр захирамжаар хийгдэж буй улсын үзлэгт байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, Архив, албан хэрэг хөтлөлтийн ажилд мэдээллийн технологи нэвтрүүлж байгаа байдал, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт гэсэн 4 чиглэлээр 93.2 %-ийн үнэлгээтэй шалгагдлаа.
- 2015 онд иргэдээс 54 өргөдөл, санал хүсэлт ирүүлснийг хуулийн хугацаанд шалган хариуг албан ёсоор хүргүүллээ.
- 2015 онд Үндэсний аудитын газраас ирүүлсэн албан бичгүүдийн дагуу шаардлагатай судалгааг хугацаанд гаргаж хүргүүлж ажиллаа.
- Улирал бүр статистик мэдээ гарган аймгийн Статистикийн хэлтэст, хагас бүтэн жилээр статистик мэдээ, үйл ажиллагааны тайлан гарган ҮАГазар хүргүүлэн ажиллаа.

Аудитыг гэрээгээр гүйцэтгүүлсэн талаар

Төрийн аудитын тухай хуулийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8.9.8 дахь заалтуудын дагуу 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгэх сонгон шалгаруулалтад шалгарсан Их Монгол Хөлөг Аудит ХХК -тай 7 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийх гэрээ байгуулан, аудитын тайлан, ажлын баримт материалыг хянаж хүлээж авлаа. Санхүүгийн тайлангийн аудитад Ж.Дамба, С.Эрдэнэцэцэг, Л.Цэцэгээ нарыг гэрээт ажилтнаар авч ажиллууллаа.

Төв аймгийн аудитын газар нь 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд гэрээгээр аудит хийх аудитын компаниудын сонгон шалгаруулалтыг 2015 оны 11-р сарын 02-ны өдөр хийлээ. Сонгон шалгаруулалтанд Их Монгол Хөлөг Аудит ХХК, Монголиан Бизнес Рейтинг Аудит ХХК, Бестгрант Аудит ХХК, Эс Эм Аудит ХХК гэсэн 4 аудитын компаниуд оролцлоо. Сонгон шалгаруулалтаар Их Монгол Хөлөг Аудит ХХК нь ОНӨҮГазар, Соёлын багцад, Бестгрант Аудит ХХК нь Эрүүл мэндийн багцад, Эс Эм Аудит ХХК нь Цэцэрлэгийн багцад гэрээгээр аудит хийхээр шалгарсан.

Олон нийтэд чиглэсэн ажлын талаар

- Төв аймагт 2015 оны 5дугаар сарын 26-29-ний өдрүүдэд “Хавдарын эсрэг аян” –ны хүрээнд Аудитын газрын хамт олон эрүүл мэндийн үзлэгт хамрагдлаа

- Говь-Алтай аймгийн аудитын газрын хамт олон 6 сард, Дундговь аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор, менежерийн хамт 5 сард ирж туршлага солилцлоо.



- Төв аймгийн Аудитын газрын аудитор, шинжээч нар нь 2015 оны 5 дугаар сарын 15-ний өдөр Нийслэлийн аудитын газрын хамт олонтой уулзалт зохион байгуулан, ажил төрлийн талаар чөлөөт ярилцлага хийлээ. Мөн хөгжөөнт тоглоом, танилцах үдэшлэг зохион явууллаа.




- Төв аймгийн төвийн албан байгууллагууд Зуунмод хотын цагаан хаалганаас МТ клонк хүртэл байгуулах “Шинэчлэл цэцэрлэгт хүрээлэн төсөл 2” арга хэмжээний хүрээнд мод тарих ажлыг хийлээ. Үүнд аудитын газрын албан хаагчид бүрэлдэхүүнээр ажиллаж Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтний хувиарласан газартаа мод тарин, услагаа хийж хүлээлгэж өглөө.

- Албан хаагчдын эрүүл мэнд, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдрыг хөгжүүлэх, хамтын харилцааг бэхжүүлэх зорилгоор Төв аймгийн төрийн байгууллагын ордонд үйл ажиллагаа явуулдаг хэлтэс, агентлагуудын ажилтнуудын дунд уламжлалт спортын тэмцээнд Төв аймгийн Аудитын газрын хамт олон амжилттай оролцож гар бөмбөг 3-р байр, сагсан бөмбөг эмэгтэй 3-р байр, ширээний теннис эмэгтэй 1-р байр, эрэгтэй 2-р байр тус тус эзэллээ.

Төв аймгийн аудитын газрын аудитор шинжээч нар дараах сургалтанд бүрэн хамрагдаж, мэдлэг туршлага, үр чадвараа дээшлүүлэн ажиллаа. Үүнд:

- Үндэсний аудитын газарт зохион байгуулсан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем (СТАУС) программын сургалтанд Төв аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан, аудитын менежер О.Амаржаргал нар 2015 оны 01 дүгээр сарын 07-ний өдөр хамрагдсан.
- СТАУС программын танилцуулга, түүнд хэрхэн ажиллах талаар SMART GREEN ХХК-ны ажилтнаар сургалтыг 2015 оны 01 дүгээр сарын 23-ний өдөр явуулж санхүүгийн тайландаа бүрэн ашиглалаа.



Үндэсний аудитын газраас нэгдсэн сүлжээнд холбогдсноор “Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт”, “Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар”, “Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүн”, “Шилэн дансны тухай хууль журмын танилцуулга”, “Шилэн дансны тухай

хуулийн хэрэгжилт” зэрэг аудитын явцын талаарх мэдээлэл солилцох онлайн хурал, сургалтанд давхардсан тоогоор 67 ажилтан хамрагдлаа.

- ММНБИ-ээс зохион байгуулсан Жижиг, дунд аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлагналын Олон улсын Стандартын сургалтанд 5 дугаар сарын 21-22-ний өдрүүдэд 6 аудитор хамрагдан, 40 кредит цагийг хангасан.
- 2015 оны 1 дүгээр сард АССА, МНБ-ийн жилийн уулзалтын нээлт болон Улаанбаатар хот Буянт ухаа цогцолборт болсон МНБ-ийн уралдаан тэмцээнд 9 аудиторыг оролцуулж 26 кт цагийг хангуулсан.
- Төв аймгийн Аудит газар 2015 оны 09-р сарын 10-нд аудитор шинжээчдийн дунд Шилэн дансны тухай хууль, журам, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартын талаар дотоод сургалтыг амжилттай зохион байгууллаа.
- УАГ-ын Стратеги удирдлагын газраас санхүүгийн аудитын удирдамж АДБОУС 1000-1810, гүйцэтгэлийн аудитын АДБОУС 3000-3100, нийцлийн аудитын АДБОУС 4000-4200 стандартуудаар СУГазрын дарга А.Сүхбаатар, менежер Х.Баярмаа, Л.Одгэрэл, Д.Энхболд нар хичээл зааж, 2 өдрийн сургалтанд аудитор, шинжээч нар бүрэн хамрагдлаа.



- Европын холбооны “Монгол улсын Стандартчиллын тогтолцоог боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх” төсөл болон Стандартчилал хэмжилзүйн газрын хамтарсан сургалтанд шинжээч Ч.Бат-Эрдэнэ 6-р сард оролцлоо.

- Улсын төсвийн байгууллага, 27-н сумын нягтлан бодогч, санхүүгийн албаны дарга нарт аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, Монголын Нягтлан бодох бүртгэлийн хүрээлэн, Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтсүүдтэй хамтарч “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт”, “Эдийн засгийн ил тод байдлын тухай хууль”-иудын талаар сургалтыг хамтран зохион байгууллаа. Сургалтын үеэр Монгол улсад хөндлөнгийн хараат бус төрийн хяналтын байгууллага үүсч хөгжсөний 20-н жилийн ой тохиож байгаатай холбогдуулан Төрийн аудитын байгууллагын түүхэн замнал, 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарах болон өмнөх аудитаар гарсан зөрчлүүдийг давтан гаргахгүй байх талаар Төв аймгийн Аудитын газрын аудитын менежер мэдээлэл хийлээ.



- Төрийн аудитын байгууллагын Мэргэжлийн тасралтгүй сургалтын хөтөлбөрийн хүрээнд 2015 онд хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөөнд тусгасны дагуу, сургалтын хэрэгцээ шаардлагад тулгуурлан, төрийн аудитын байгууллагын харьяа аудитын газруудын мэдээлэл технологи хариуцсан ажилтнуудын сургалтанд шинжээч Ч.Бат-Эрдэнэ 2015 оны 12 дүгээр сарын 07-ны өдрөөс 12 дугаар сарын 12-ны өдөр хүртэл хамрагдлаа. Уг сургалтаар төрийн аудитын төв болон орон нутгийн аудитын газруудыг шилэн кабелийн холболттой өндөр хурдны, нууцлалын өндөр түвшинд нэгдсэн сүлжээнд холбож мэдээлэл, технологийн онлайн орчин, eOffice-ын програм хангамжийг нэвтрүүлсэн. Энэхүү нэгдсэн сүлжээ болон түүний орчинд ажиллах eOffice-ын програм хангамжуудыг үр дүнтэй ажиллуулах, ашиглахад

мэдээлэл технологи хариуцсан ажилтны ур чадварыг дээшлүүлэх үүднээс тус сургалтыг зохион байгуулсан байна.

- ТАБ-ын ажилтны тасралтгүй сургалтын хөтөлбөр төлөвлөгөөний дагуу Санхүүгийн аудитын гарын авлага, мөн АДБОУС-ууд, шинээр гарсан журмууд, баримт бичгийн стандарт, хадгаламжийн нэгж бүрдүүлэх талаар дотоодоо 24 сэдвээр сургалт зохион байгууллаа.



САЙН ҮЙЛС ДЭЛГЭРЭХ БОЛТУГАЙ

*ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР*